



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 39 (324)

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ:

- *Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай*
- *Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай*

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ:

- *Монголбанкны Хяналтын зөвлөлийн ажиллах журам батлах тухай*

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ:

- *Нийгмийн халамжийн тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот

2003 он



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот

2003 оны аравдугаар сарын 22

№ 39 (324)

## Гарчиг

### Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

- |      |   |     |
|------|---|-----|
| 537. | Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай<br>(2003-10-9-ний хууль)           | 873 |
| 538. | Нэмэгдсэн өртгийн албан татвараас<br>чөлөөлөх тухай (2003-10-9-ний хууль) | 873 |

### Хоёр. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

- |      |   |           |     |
|------|---|-----------|-----|
| 539. | Монголбанкны Хяналтын зөвлөлийн<br>ажиллах журам батлах тухай | Дугаар 39 | 874 |
|------|---|-----------|-----|

### Гурав. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

- |      |  |            |     |
|------|--|------------|-----|
| 540. | Нэрэмжит болгох тухай  | Дугаар 211 | 876 |
| 541. | Нийгмийн халамжийн тэтгэврийн<br>хэмжээг нэмэгдүүлэх тухай                             | Дугаар 212 | 876 |
| 542. | Журам батлах тухай   | Дугаар 213 | 877 |
| 543. | "НИК" хувьцаат компанийн нийт<br>хувьцааны төрийн эзэмшлийн<br>хувьцааг хувьчлах тухай | Дугаар 215 | 880 |

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2003 оны 10 дугаар  
сарын 9-ний өдөр

Улаанбаатар  
хот

### ГААЛИЙН АЛБАН ТАТВАРААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Засгийн газрын төхөөрөмжийг гаалийн албан татвараас хэрэгжүүлэгч агентлаг Шуудан, цахилгаан холбооны газрын хөрөнгө оруулалтаар хэрэгжиж чөлөөлсүгэй.

байгаа "Булган-Мөрөнгийн хооронд агаарын шилэн кабелийн дамжуулах сүлжээ байгуулах" төслийн хүрээнд импортоор нийлүүлэгдэх материал, тоног

МОНГОЛ УЛСЫН ИХ  
ХУРЛЫН ДАРГА

С.ТӨМӨР-ОЧИР

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2003 оны 10 дугаар  
сарын 9-ний өдөр

Улаанбаатар  
хот

### НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Засгийн газрын төхөөрөмжийг нэмэгдсэн өртгийн албан татвараас хэрэгжүүлэгч агентлаг Шуудан, цахилгаан холбооны газрын хөрөнгө оруулалтаар хэрэгжиж чөлөөлсүгэй.

байгаа "Булган-Мөрөнгийн хооронд агаарын шилэн кабелийн дамжуулах сүлжээ байгуулах" төслийн хүрээнд импортоор нийлүүлэгдэх материал, тоног

МОНГОЛ УЛСЫН ИХ  
ХУРЛЫН ДАРГА

С.ТӨМӨР-ОЧИР



## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2003 оны 10 дугаар сарын 9-ний өдөр

Дугаар 39

Улаанбаатар хот

Монголбанкны Хяналтын зөвлөлийн ажиллах журам батлах тухай

Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн 27<sup>1</sup> дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

2. Энэ тогтоолыг 2003 оны 11 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

1. "Монголбанкны Хяналтын зөвлөлийн ажиллах журам"-ыг хавсралт ёсоор баталсугай.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР**

*Улсын Их Хурлын 2003 оны 39 дүгээр тогтоолын хавсралт*

### МОНГОЛБАНКНЫ ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

#### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн 27<sup>1</sup> дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу Монголбанкны Хяналтын зөвлөл /цаашид "Хяналтын зөвлөл" гэх/-ийн үйл ажиллагааг зохицуулахад энэхүү журмыг мөрдөнө.

1.2. Хяналтын зөвлөл нь Төв банк /Монголбанк/-ны тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж, энэхүү журмыг удирдлага болгон үйл ажиллагаагаа явуулна.

1.3. Хяналтын зөвлөл нь Монголбанкны дотоод хяналтын үйл ажиллагаа, хөндлөнгийн аудитын санал, зөвлөмжийн хэрэгжилт, хөрөнгө оруулалтын багц болон Монголбанкнаас санхүүгийн тайлангаа Улсын Их Хурал, олон нийтэд тайлагнаж, мэдээлж байгаа байдал, Монголбанкны Зөвлөлийн үйл ажиллагааны үр дүнд хяналт тавих эрх бүхий орон тооны бус байгууллага байна.

1.4. Хяналтын Зөвлөл нь тэмдэг, тогтоосон загвараар үйлдсэн албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

#### Хоёр. Хяналтын зөвлөлийн чиг үүрэг

2.1. Хяналтын зөвлөл нь дараахь чиг үүрэгтэй.

2.1.1. үйл ажиллагаа нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын зарчимд нийцсэн хөндлөнгийн аудитын байгууллагыг Монголбанкны жилийн санхүүгийн тайланд аудит хийлгэхээр сонгох явцад хяналт тавих;

2.1.2. хөндлөнгийн аудитын дүгнэлт, зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар Монголбанкнаас хийж буй ажилтай танилцаж, биелэлтэд хяналт тавих;

2.1.3. хөндлөнгийн аудитын үйл ажиллагаа нягтлан бодох бүртгэлийн олон улсын зарчимд нийцэж явагдаж байгаа эсэхийг хянах;

2.1.4. Монголбанкны Зөвлөлийн үйл ажиллагааны үр дүнд хяналт тавих;

2.1.5. Монголбанкнаас Улсын Их Хурал, олон нийтэд мэдээлсэн санхүүгийн тайлантай танилцаж, дүгнэлт өгөх;

2.1.6. дотоод хяналтын талаар гаргасан журам, дотоод хяналтын үйл ажиллагааны хөтөлбөр, төлөвлөгөө, тэдгээрийн хэрэгжилтийн байдалтай танилцаж, холбогдох арга хэмжээ авахыг Монголбанкны удирдлагад санал болгох;

2.1.7. хөрөнгө оруулалтын багцад хяналт тавих;

2.1.8. Монголбанкны ашиг хуваарилсан нөөцийн сангуудад хийсэн гүйлгээтэй танилцах;

2.1.9. хуульд заасан бусад чиг үүрэг.

#### Гурав. Хяналтын зөвлөлийн бүрэн эрх

3.1. Хяналтын зөвлөл дараахь бүрэн эрхтэй:

3.1.1. Монголбанкны дотоод аудитын газрын үйл ажиллагааны тайлан болон Монголбанкны санхүүгийн тайлан, түүнтэй холбоотой бусад мэдээллийг Монголбанкнаас гаргуулан авах;

3.1.2. өөрийн бүрэн эрхэд хамаарах асуудлаар Монголбанкинд өгсөн санал, зөвлөмжийн хэрэгжилтийн талаар зохих албан тушаалтны илтгэл, сонсголыг Хяналтын зөвлөлийн хурлаар хэлэлцэх;



3.1.3. хөндлөнгийн аудиторын Монголбанкны үйл ажиллагааны талаарх дүнгэлт, зөвлөмжийн талаар тайлбар, саналыг сонсох;

3.1.4. Монголбанкны дотоод аудитын газрын хянан шалгагчтай харилцаж, дотоод хяналттай холбогдсон асуудлаар санал солилцох;

3.1.5. шаардлагатай гэж үзвэл Монголбанкны үйл ажиллагаа, менежментийн аливаа асуудал, тодорхой гүйлгээнд шалгалт, аудит хийлгэх санал гаргах;

3.1.6. Монголбанкны Зөвлөлийн үйл ажиллагааны үр дүнг хэлэлцэн дүнгэлт гаргах;

3.1.7. өөрийн бүрэн эрхэд хамаарах асуудлын талаар Улсын Их Хуралд мэдээлэх;

3.1.8. Хяналтын зөвлөлийн хурлаар хэлэлцсэн аливаа асуудлын биелэлтийг хангаж ажиллахыг Монголбанкны удирдлагад зөвлөх;

3.1.9. Монголбанкны дотоод хяналт, санхүүгийн тайлан гаргах эрх зүйн орчныг боловсронгуй болгох талаар санал гаргах;

3.1.10. хуульд заасан бусад бүрэн эрх.

3.2. Хяналтын зөвлөлийн дарга нь Хяналтын зөвлөлийн гишүүний бүрэн эрхийг эдлэхээс гадна дараахь бүрэн эрхтэй:

3.2.1. Хяналтын Зөвлөлийг тэргүүлж, хуралдааныг товлох, даргалах;

3.2.2. өөрийн эзгүйд хурал даргалах гишүүнийг томилох;

3.2.3. Хяналтын зөвлөлийн шийдвэрийн биелэлтэд хяналт тавихыг Хяналтын зөвлөлийн гишүүнд хуваарилан хариуцуулах.

3.3. Хяналтын зөвлөлийн гишүүн дараахь эрхтэй:

3.3.1. Хяналтын зөвлөлийн хуралд асуудал оруулж хэлэлцүүлэх;

3.3.2. Хяналтын зөвлөлийн чиг үүрэгт хамаарах тодорхой асуудлыг хариуцан ажиллаж, гүйцэтгэл, үр дүнгийн талаар Хяналтын зөвлөлийн хуралд мэдээлэх;

3.3.3. Хяналтын зөвлөлийн шийдвэрийн дагуу Монголбанкны Зөвлөлийн болон Монголбанкны дотоод хяналтын үйл ажиллагаатай танилцах;

3.3.4. Хяналтын зөвлөлийн шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг Хяналтын зөвлөлийн хуралд мэдээлэх;

3.3.5. Хяналтын зөвлөлийн чиг үүрэгт холбогдох асуудлаар Монголбанкнаас баримт материал гаргуулан авах.

## Дөрөв. Хяналтын зөвлөлийн хурал

4.1. Хяналтын зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь Хяналтын зөвлөлийн хурал /цаашид "зөвлөлийн хурал" гэх/ байна.

4.2. Зөвлөлийн хурлыг Хяналтын зөвлөлийн дарга удирдах бөгөөд түүний эзгүйд түүний томилсон гишүүн хурлыг удирдан явуулна.

4.3. Хяналтын зөвлөл нь улиралд нэгээс доошгүй удаа хуралдана. Ээлжит бус хурлыг зөвлөлийн даргын санаачилга, эсхүл гишүүдийн дийлэнх олонхийн саналаар зарлан хуралдуулж болно.

4.4. Хяналтын зөвлөлийн хурал нь гишүүдийн олонхи оролцооноор хүчин төгөлдөр болно.

4.5. Хяналтын зөвлөлийн хурлаар хэлэлцэх асуудлыг зөвлөлийн ажлын алба гишүүдэд хурал эхлэхээс ажлын тав хоногийн өмнө бичгээр тараасан байна.

4.6. Хяналтын зөвлөл нь зөвлөлийн хурлаар хэлэлцсэн асуудлаа хуралд оролцож буй гишүүдийн олонхийн саналаар шийдвэрлэх бөгөөд гишүүдийн санал тэнцсэн тохиолдолд хурал даргалагчийн саналаар асуудлыг шийдвэрлэнэ.

4.7. Хяналтын зөвлөл нь зөвлөлийн хурлаар хэлэлцсэн асуудлын талаар Улсын Их Хуралд мэдээлэл өгөхөөс гадна Монголбанкны удирдлагад тодорхой асуудлын биелэлтийг хангахыг зөвлөсөн шийдвэр гаргана. Хяналтын зөвлөлийн шийдвэрийн хэлбэр нь тогтоол байх бөгөөд тогтоолд Хяналтын зөвлөлийн дарга гарын үсэг зурна.

4.8. Хяналтын зөвлөлийн шийдвэрийн хэрэгжилт, тайлбарыг Монголбанкны удирдлага Хяналтын зөвлөлийн хуралд танилцуулна.

4.9. Зөвлөлийн хурлын тэмдэглэлийг Хяналтын зөвлөлийн ажлын албаны ажилтан хөтлөх бөгөөд тэмдэглэл нь хураангуй болон дэлгэрэнгүй гэсэн хоёр хэлбэртэй байна.

4.10. Зөвлөлийн хурлын тэмдэглэлд хурал даргалагч, тэмдэглэл хөтлөгч гарын үсэг зурсан байна.

4.11. Зөвлөлийн хурлын тэмдэглэл хөтлөгч нь хэлэлцсэн асуудлаар гишүүдээс хэлсэн үг, тавьсан саналыг хурлын дэлгэрэнгүй тэмдэглэлд үнэн зөв, бүрэн гүйцэд бичиж тэмдэглэнэ.

4.12. Зөвлөлийн хурлаар хэлэлцэж шийдвэрлээд хураангуй тэмдэглэлд тусгасан шийдвэрт дараа нь утга агуулгын өөрчлөлт оруулахыг хориглоно.

4.13. Зөвлөлийн хурлын хураангуй тэмдэглэлд тухайн хурлаар хэлэлцсэн асуудлын жагсаалт, холбогдох материалыг хавсаргасан байна.

### Тав. Хяналтын зөвлөлийн ажлын алба

5.1. Хяналтын зөвлөл нь хурлын бэлтгэл ажлыг хангах, хурлын явцад тэмдэглэл хөтлөх, дарга, гишүүдийг шуурхай мэдээллээр хангах, Хяналтын зөвлөлөөс үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхэд туслах, гаргасан шийдвэрийн биелэлтийг хангуулах чиг үүрэг бүхий ажлын албатай байна.

5.2. Хяналтын зөвлөлийн ажлын албаны бүтэц, орон тоо, цалингийн санг Хяналтын зөвлөл Монголбанкны Ерөнхийлөгчтэй зөвшилцөн тогтооно.

### Зургаа. Хяналтын зөвлөлийн дарга, гишүүдийн ажлын хөлс, зардал

6.1. Хяналтын зөвлөлийн дарга, гишүүдэд түүний Хяналтын зөвлөлийн ажилд оролцсон байдлыг харгалзан ажлын хөлс олгох бөгөөд түүний хэмжээ, ажлын хөлс олгох журмыг Улсын Их

Хурлын Эдийн засгийн байнгын хороотой зөвшилцөн Монголбанкны Ерөнхийлөгч батална.

6.2. Хяналтын зөвлөл, түүний ажлын албаны үйл ажиллагаанд шаардагдах зардлыг тогтсон жишгийн дагуу Монголбанкнаас гаргана.

### Долоо. Хяналтын зөвлөлийн дарга, гишүүнийг томилох, нөхөн томилох

7.1. Хяналтын зөвлөлийн дарга, гишүүнийг Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн 27<sup>д</sup> дүгээр зүйлийн 3, 4 дэх хэсэгт заасны дагуу томилно.

7.2. Хяналтын зөвлөлийн дарга, гишүүн нь хугацаанаасаа өмнө үүрэгт ажлаасаа чөлөөлөгдсөн тохиолдолд түүнийг нөхөн томилно.

7.3. Хяналтын зөвлөлийн гишүүнийг нэг удаа улируулан томилж болно.

### Найм. Хяналтын зөвлөлөөс Улсын Их Хуралтай харилцах

8.1. Хяналтын зөвлөл нь Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн 27<sup>д</sup> дугаар зүйлийн 9 дэх хэсгийн 4-т заасны дагуу өөрийн үйл ажиллагааны тайланг Улсын Их Хуралд хүргүүлж байна.

8.2. Хяналтын зөвлөл нь өөрийн чиг үүрэгт хамаарах асуудлын талаарх мэдээллийг Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлнэ.

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2003 оны 9 дүгээр сарын 24-ний өдөр

Дугаар 211

Улаанбаатар хот

### Нэрэмжит болгох тухай

Түүхэн үйл явдал тэмдэглэх, төр, нийгмийн зүтгэлтэн, гавьяат үйлстнийг алдаршуулах, дурсгалыг нь хүндэтгэх ажлыг зохион байгуулах журам, холбогдох байгууллага, хамт олны саналыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

соёлын гавьяат зүтгэлтэн Жамцын Бадраагийн нэрэмжит болгосугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

Н.ЭНХБАЯР

Хөвсгөл аймгийн Мөрөн сумын "Дэлгэрмөрөн" цогцолбор сургуулийг Монгол Улсын

Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд

А.ЦАНЖИД

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2003 оны 9 дүгээр сарын 24-ний өдөр

Дугаар 212

Улаанбаатар хот

### Нийгмийн халамжийн тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай

Нийгмийн халамжийн тухай хуулийн 13 дугаар зүйлийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Ч.Улаан, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Ш.Батбаяр нарт даалгасугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

Н.ЭНХБАЯР

Нийгмийн халамжийн сангаас олгох тэтгэврийн хэмжээг 20 хувиар нэмэгдүүлж 2003 оны 10 дугаар сарын 1-нээс эхлэн тооцон олгох арга хэмжээ авахыг Санхүү, эдийн засгийн сайд

Санхүү, эдийн засгийн сайд

Ч.УЛААН

Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд

Ш.БАТБАЯР



## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2003 оны 9 дүгээр сарын 25-ны өдөр

Дугаар 213

Улаанбаатар хот

### Журам батлах тухай

Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 9.2-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Журам шинэчлэн батлах тухай" Засгийн газрын 2001 оны 2 дугаар сарын 26-ны өдрийн 40 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

1. "Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн үйл ажиллагааны үйлчилгээний хөлс, түүний орлогыг захиран зарцуулах журам"-ыг хавсралт ёсоор баталсугай.

Монгол Улсын  
Ерөнхий сайд

Н.ЭНХБАЯР

Монгол Улсын сайд,  
Засгийн газрын Хэрэг  
эрхлэх газрын дарга Ө.ЭНХТҮВШИН

*Засгийн газрын 2003 оны 213 дугаар тогтоолын хавсралт*

### ЭД ХӨРӨНГӨ ӨМЧЛӨХ ЭРХ, ТҮҮНТЭЙ ХОЛБООТОЙ ЭД ХӨРӨНГИЙН БУСАД ЭРХИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨЛС, ТҮҮНИЙ ОРЛОГЫГ ЗАХИРАН ЗАРЦУУЛАХ ЖУРАМ

#### Нэг. Нийтлэг үндэслэл

г/ев залгамжлах;  
д/шүүхийн шийдвэрээр;  
е/өмчлөгчийн хүсэлтээр (хувь хүний өмчлөлөөс тухайн хүний өөрийнх нь аж ахуйн нэгжийн өмчлөлд, эсхүл аж ахуйн нэгжийн өмчлөлөөс тухайн аж ахуйн нэгжид хөрөнгө оруулагч хувь хүн, аж ахуйн нэгжийн өмчлөлд шилжсэн гэх мэт);  
ж/албадан дуудлага худалдаагаар худалдагдсан.

1.1. Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн дагуу эрхийн улсын бүртгэлийн алба (орон нутаг дахь эрхийн улсын бүртгэгч)-наас үзүүлдэх үйлчилгээний төрөл, хөлсний хэмжээ, түүний орлогыг захиран зарцуулахад энэ журмыг дагаж мөрдөнө.

1.2. Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн үйл ажиллагааны үйлчилгээний хөлсийг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас өмчийн хэлбэрийг үл харгалзан хураана.

2.3. хамтран өмчлөгч нэмэгдсэн, хасагдсаныг бүртгэх;

2.4. эрхийн улсын бүртгэлд өөрчлөлт, залруулга хийх. Үүнд дараахь бүртгэл хамаарна:

#### Хоёр. Хөлс төлөх үйлчилгээний төрөл

2. Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн дараахь үйлчилгээнд хөлс авна:

а/эд хөрөнгийн хэмжээ өөрчлөгдсөнийг бүртгэх;

б/эд хөрөнгийн оршин байгаа газрын харьяалал өөрчлөгдсөнийг бүртгэх;

2.1. төрөөс үнэ төлбөргүй хувьчилсан газар болон орон сууц өмчлөх эрхийг баталгаажуулах;

в/өмчлөгчийн буруугаас эрхийн улсын бүртгэлд буруу мэдээлэл бүртгэгдсэнийг залруулах.

2.2. эд хөрөнгө өмчлөх эрх өөр этгээдэд шилжсэннийг бүртгэх. Үүнд дараахь эрхийн бүртгэл хамаарна:

2.5. гэрээг сунгасан, цуцалсан, дуусгавар болсныг бүртгэх;

а/худалдах, худалдан авах;

б/бэлэглэх;

в/арилжих;

2.6. эрхийн улсын бүртгэлд тусгай тэмдэглэл хийх. Үүнд дараахь бүртгэл хамаарна:





а/өмчлөгчийг иргэний эрх зүйн чадамжгүйд, эсхүл сураггүй алга болсонд тооцсон, нас барсан гэж зарласан тухай бүртгэх;

б/иргэний хуулийн 453.2-т заасан үндэслэлээр захиран зарцуулах эрх шилжсэнийг бүртгэх.

2.7. эрхийн улсын бүртгэлд урьдчилсан тэмдэглэл хийх. Үүнд дараахь бүртгэл хамаарна:

а/гэрээслэгчийн хүсэлтээр урьдчилсан тэмдэглэл хийх;

б/өмчлөгч болон худалдан авагчийн хүсэлтээр урьдчилсан тэмдэглэл хийх.

2.8. энэ журамд заасан урьдчилсан тэмдэглэл, тусгай тэмдэглэлийг хүчингүй болгож;

2.9. эд хөрөнгийн барьцааны эрхийг бүртгэх;

2.10. эд хөрөнгийн барьцааны эрхийн улсын бүртгэлд өөрчлөлт орсныг бүртгэх:

а/ипотек өөр этгээдэд шилжсэнийг бүртгэх;

б/ипотек өмчлөгчид шилжсэнийг бүртгэх;

в/ипотекээр хангагдах шаардлагыг өөр шаардлагаар сольсныг бүртгэх.

2.11. үл хөдлөх эд хөрөнгө түрээслэснийг бүртгэх;

2.12. сервитутыг бүртгэх;

2.13. узуфруктыг бүртгэх;

2.14. бусдын газар дээр барилга, байгууламж барих эрхийг бүртгэх;

2.15. хуульд өөрөөр заагаагүй бол газар зээмших, ашиглах эрхийг бүртгэх;

2.16. Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 6.2; 6.4;6.5-д заасан журмын дагуу лавлагаа,хуулбар гаргаж өгөх;

2.17. эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээг үрэгдүүлсэн тохиолдолд түүнийг хүчингүй болгож, нөхөн олгох;

2.18. эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээг гэмтээсэн тохиолдолд түүнийг хүчингүй болгож, нөхөн олгох;

2.19. эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэл, хувийн хэргийг хаах.

### Гурав. Хөлсний хэмжээ

3. Эрхийн улсын бүртгэлийн үйл ажиллагаанд дор дурдсан үйлчилгээний хөлс авна:

3.1. төрөөс үнэ төлбөргүй хувьчилсан газар болон орон сууцны өмчлөх эрхийг баталгаажуулахад 2500 төгрөг;

3.2. эд хөрөнгө өмчлөх эрх өөр этгээдэд шилжсэнийг бүртгэхэд дор дурдсанаар хөлс авна:

| Өмчлөх эрх шилжүүлэх үндэслэл                              | Өмчлөх эрхийг шилжүүлж байгаа гэрээний үнийн дүн (төгрөг)                          | Хөлс (төгрөг)          |
|--|--|------------------------|
| Худалдах, худалдан авах гэрээ                              | 10.000.000 хүртэл<br>10.000.001-100.000.000<br>100.000.000-аас дээш                | 8000<br>25000<br>60000 |
| Бологдох гэрээ   | 10.000.000 хүртэл<br>10.000.001-100.000.000<br>100.000.000-аас дээш                | 8000<br>25000<br>60000 |
| Ариутгах гэрээ   | Эд хөрөнгийн үнэ, хэмжээ, зориулалтаас үл хамааран гэрээнд оролцогч талууд тус бүр | 15000                  |
| Өв залгамжлах  | Эд хөрөнгийн үнэ, хэмжээ, зориулалтаас үл хамааран                                 | 5000                   |
| Шүүхийн шийдвэрээр   | Эд хөрөнгийн үнэ, хэмжээ, зориулалтаас үл хамааран                                 | 5000                   |
| Өмчлөгчийн хүсэлтээр                                       | Эд хөрөнгийн үнэ, хэмжээ, зориулалтаас үл хамааран                                 | 5000                   |
| Албандан дуудлага худалдаагаар худалдаагдсан тулалдаагдсан | 10.000.000 хүртэл<br>10.000.001-100.000.000<br>100.000.000-аас дээш                | 5000<br>10000<br>20000 |

3.3. хамтран өмчлөгч нэмэгдсэн, хасагдсаныг бүртгэхэд өмчлөгч тус бүр 3000 төгрөг;

3.4. эрхийн улсын бүртгэлд өөрчлөлт, залруулга хийхэд 3000 төгрөг;

3.5. эрхийн улсын бүртгэлд тусгай тэмдэглэл, урьдчилсан тэмдэглэл хийхэд 3000 төгрөг;

3.6. эд хөрөнгийн барьцааны эрхийг эрхийн улсын бүртгэлд бүртгэхэд барьцаагаар хангагдах үүргийн үнийн дүнгийн 0.1 хувиар бодож;

3.7. эд хөрөнгийн барьцааны эрхийн улсын бүртгэлд өөрчлөлт орсныг бүртгэхэд 5000 төгрөг;

3.8. гэрээг сунгасан, цуцалсан, дуусгавар болсныг бүртгэх, энэ журмын 3.5-д заасан

урьдчилсан тэмдэглэл, тусгай тэмдэглэлийг хүчингүй болгоход 3000 төгрөг;

3.9. үл хөдлөх эд хөрөнгө түрээслэснийг бүртгэхэд 20000 төгрөг;

3.10. сервитутыг бүртгэхэд гэрээнд оролцогч талууд тус бүрээс 3000 төгрөг;

3.11. узуфруктыг бүртгэхэд гэрээнд оролцогч талууд тус бүрээс 3000 төгрөг;

3.12. бусдын газар дээр барилга, байгууламж барих эрхийг эрхийн улсын бүртгэлд бүртгэхэд 10000 төгрөг;

3.13. газар эзэмших, ашиглах эрхийг эрхийн улсын бүртгэлд бүртгэхэд 10000 төгрөг;

3.14. Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 6.4-т заасан мэдээллийг агуулсан лавлагаа өгөхөд 3000 төгрөг;

3.15. Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 6.5-д заасны дагуу дэлгэрэнгүй мэдээлэл агуулсан лавлагаа өгөхөд 5000 төгрөг. Лавлагааг зөвхөн бичгээр өгнө;

3.16. Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 6.2-т заасны дагуу хуулбар хийхэд хуудас бүрээс 1000 төгрөг;

3.17. эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээг үрэгдүүлсэн тохиолдолд түүнийг хүчингүй болгож, нөхөн олгоход 45000 төгрөг;

3.18. эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээг гэмтээсэн тохиолдолд түүнийг хүчингүй болгож, нөхөн олгоход 20000 төгрөг;

Гэмтээсэн гэрчилгээг өмчлөх эрхийн улсын бүртгэлийн материалд хавсарган хадгална.

3.19. эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэл, хувийн хэргийг хаахад 3000 төгрөг;

3.20. эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн мэдүүлгийн хуудасны үнэ 100 төгрөг, эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн

гэрчилгээний үнэ 5000 төгрөг, эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн хувийн хэргийн үнэ 2500 төгрөг;

3.21. Иргэний хуулийн 182.2, Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 3.7-д зааснаар хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрхийг эрхийн улсын бүртгэлд бүртгэхэд тухайн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлд тусгасан үнийн 1 хувиар бодож хөлс авах бөгөөд өмчлөх эрхтэй холбоотой бусад эрхийг эрхийн улсын бүртгэлд бүртгэхэд энэ журамд заасныг баримтлан үйлчилгээний хөлс авна;

3.22. үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийн эрхийн улсын бүртгэлд анхны удаа бүртгэхэд Тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 17<sup>2</sup> дугаар зүйлд заасны дагуу тухайн үл хөдлөх эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлд тусгасан үнийн 0.01 хувиар бодож тэмдэгтийн хураамж авна. Энэ тохиолдолд үйлчилгээний хөлс авахгүй;

3.23. Энэ журмын 2 дугаар зүйлд зааснаас бусад төрлийн үйлчилгээнд хөлс авахгүй.

## **Дөрөв. Яаралтай үйлчилгээ үзүүлсний хөлс, түүний хэмжээ**

4.1. энэ журмын 2.17, 3.22-т зааснаас бусад төрлийн эрхийг эрхийн улсын бүртгэлд бүртгэхэд баримт бичгийн бүрдэл нь эрхийн улсын бүртгэлийн шаардлага хангасан тохиолдолд үйлчлүүлэгчийн хүсэлтээр яаралтай үйлчилгээ үзүүлж болно;

4.2. яаралтай үйлчилгээг ажлын 8 цагт багтаах бөгөөд энэ журмын 3 дугаар зүйлд заасан хөлсний хэмжээг 2 дахин нэмэгдүүлж авч болно.

## **Тав. Үйлчилгээний хөлсийг захиран зарцуулах**

5.1. үйлчилгээ үзүүлснээс орсон орлогыг Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын үйл ажиллагааны болон эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 10.5-д заасныг хэрэгжүүлэхэд зориулсан зардлыг санхүүжүүлэх болон төсөв бүрдүүлэхэд зарцуулна.

5.2. Үйлчилгээ үзүүлснээс орсон орлого, зарлагыг зохих журмын дагуу санхүү, эдийн засгийн байгууллагад тайлагнана.





## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2003 оны 10 дугаар сарын 1-ний өдөр

Дугаар 215

Улаанбаатар хот

### "НИК" хувьцаат компанийн нийт хувьцааны төрийн эзэмшлийн хувьцааг хувьчлах тухай

Төрийн өмчийг 2001-2004 онд хувьчлах үндсэн чиглэл, Төрийн өмчийг 2002 онд хувьчлах хөтөлбөрийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "НИК" хувьцаат компанийн нийт хувьцааны төрийн эзэмшлийн 80 хувь буюу 16.760.768 /арван зургаан сая долоон зуун жаран мянга долоон зуун жаран найман/ ширхэг хувьцааг хувьчлах "Уралдаант шалгаруулалт /тендер/-ын зар мэдээ"-г 1 дүгээр, "Уралдаант шалгаруулалт /тендер/-ын журам"-ыг 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. "НИК" хувьцаат компанийн нийт хувьцааны төрийн эзэмшлийн 80 хувь буюу 16.760.768 /арван зургаан сая долоон зуун жаран мянга долоон зуун жаран найман/ ширхэг хувьцааг хувьчлах доод үнийг 6.133.000 /зургаан сая нэг зуун гучин гурван мянган/ ам. доллараар тогтоосугай.

3. Төрийн өмчийн хороо /Л.ПҮРЭВДОРЖ/-нд даалгах нь:

а/"НИК" хувьцаат компанийн нийт хувьцааны төрийн эзэмшлийн 80 хувь буюу 16.760.768 /арван зургаан сая долоон зуун жаран мянга долоон зуун жаран найман/ ширхэг хувьцааг хувьчлах "Уралдаант шалгаруулалт /тендер/-ын зар мэдээ"-г дотоод, гадаадын хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлж сурталчилсугай;

б/"НИК" хувьцаат компанийн нийт хувьцааны төрийн эзэмшлийн 80 хувь буюу

16.760.768 /арван зургаан сая долоон зуун жаран мянга долоон зуун жаран найман/ ширхэг хувьцааг хувьчлах уралдаант шалгаруулалт /тендер/-ыг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Уралдаант шалгаруулалт /тендер/-ын журмын дагуу зохион байгуулж явуулсугай;

в/"НИК" хувьцаат компанийн нийт хувьцааны төрийн эзэмшлийн 80 хувь буюу 16.760.768 /арван зургаан сая долоон зуун жаран мянга долоон зуун жаран найман/ ширхэг хувьцааг хувьчлах уралдаант шалгаруулалт /тендер/-д яасан худалдан авагчтай уралдаант шалгаруулалт /тендер/-ын журамд заасан болзол, нөхцөлийн талаар харилцан тохиролцож, Хувьцаа худалдах, худалдан авах гэрээг байгуулсугай.

4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "НИК" хувьцаат компанийн өр төлбөрийг шийдвэрлэх, нийт хувьцааны төрийн эзэмшлийн хувьцааг хувьчлах тухай" Засгийн газрын 2003 оны 1 дүгээр сарын 22-ны өдрийн 19 дүгээр тогтоолын 3, 4, 5 дугаар зүйлийг хүчингүй болсонд тооцсугай.

|                               |           |
|-------------------------------|-----------|
| Монгол Улсын<br>Ерөнхий сайд  | Н.ЭНХБАЯР |
| Санхүү, эдийн<br>засгийн сайд | Ч.УЛААН   |

Засгийн газрын 2003 оны 215 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

### ТӨРИЙН ӨМЧИЙН ХОРОО

#### УРАЛДААНТ ШАЛГАРУУЛАЛТ /ТЕНДЕР/-ЫН ЗАР МЭДЭЭ

Монгол Улсын Их Хурлын 2001 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 10 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн өмчийг 2001-2004 онд хувьчлах үндсэн чиглэл", Засгийн газрын 2001 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн 9 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн өмчийг 2002 онд хувьчлах хөтөлбөр"-ийн дагуу нефтийн бүтээгдэхүүний Монгол Улсын хамгийн том импортлогч, борлуулагч болох "НИК" хувьцаат компани /цаашид "НИК" ХК буюу "компани" гэх/-ийн нийт хувьцааны 80 хувьд ногдох 16.760.768 /арван зургаан сая долоон зуун жаран мянга долоон зуун жаран найман/ ширхэг энгийн багц хувьцааг уралдаант шалгаруулалт /цаашид "тендер" гэх/-ын аргаар хувьчлах үйл ажиллагаанд оролцох стратегийн хөрөнгө оруулагчид /гадаадын буюу дотоодын хуулийн этгээд эсхүл тэдгээрийн оролцоотой консорциум/-ыг Монгол Улсын Засгийн газраас урьж байна.

Тендерийг Монгол Улсын Засгийн газрын 2003 оны 10 дугаар сарын 1-ний өдрийн 215 дугаар тогтоолоор батлагдсан "Уралдаант шалгаруулалт /тендер/-ын журам"-д заасан нөхцөл, болзлын дагуу Төрийн өмчийн хороо /цаашид "ТӨХ" гэх/-ноос зохион байгуулж явуулна. Засгийн газрын шийдвэрээр компанийн нийт хувьцааны 80 хувийг худалдах доод үнийг 6133000 /зургаан сая нэг зуун гучин гурван мянган/ ам. доллараар тогтоов. "НИК" хувьцаат компанийн нийт хувьцааны 80 хувьд ногдох төрийн эзэмшлийн багц хувьцааг худалдан авах 6133000 /зургаан сая нэг зуун гучин гурван мянган/ ам. доллараас доошгүй үнийг бүрэн төлвөл Санхүү, эдийн засгийн яаманд компаниас төлөх 7413978000 /долоон тэрбум дөрвөн зуун арван гурван сая есөн зуун далан найман мянган/ төгрөгийн тусламжийн барааны ерийг Засгийн газар өршөөж, компанийг энэ ерөөс чөлөөлнө.

"НИК" ХК-ийг хувьчлах ажилд Монгол Улсын Засгийн газраас АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлагтай байгуулсан гэрээний дагуу "Бэринг Пойнт" компанийн "Барентс бүлэг" нь ТӨХ-ны зөвлөхөөр ажиллаж байгаа болно.

### Тендерт оролцох өргөдөл гаргах/ сонирхлоо илэрхийлэх

Нефть, нефтийн бүтээгдэхүүний салбарын хөрөнгө оруулагч, эсхүл түүний оролцоотой консорциум зэрэг шаардлага хангасан хөрөнгө оруулагчдыг өргөдөл гаргаж, сонирхлоо илэрхийлэхийг урьж байна.

Тендерийн зар мэдээ гарсны дараа тендерт оролцох хүсэлтэй этгээд /цаашид "өргөдөл гаргагч" гэх/ нь сонирхлоо илэрхийлсэн албан ёсны захидлыг дараахь материалын хамт англи буюу монгол хэлний аль нэг дээр бэлтгэж ТӨХ-нд ирүүлнэ. Үүнд:

1. Өргөдөл;
2. Зохиж журмын дагуу үйлдэж, өргөдөл гаргагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч гарын үсэг зурсан нууцгүй хадгалах тухай гэрээ;
3. Буцааж төлөгдөхгүй нөхцөлтэй 1,000 /нэг мянган/ ам. долларын тендерийн хураамж төлснийг нотлох баримт;
4. Итгэмжлэгдсэн төлөөлөгчийн төлөөлөх эрхийг баталгаажуулсан итгэмжлэл;
5. Өргөдөл гаргагчийн танилцуулга. Үүнд дараахь зүйлийг оруулсан байх шаардлагатай:

Тендерт оролцох сонирхлоо илэрхийлж буй компанийн албан ёсны нэр, хаяг болон үйл ажиллагааны танилцуулга / консорциумаар оролцож байгаа тохиолдолд энэхүү мэдээллийг консорциумын гишүүн тус бүрээр гаргаж өгнө/.

Өргөдөл гаргагчийн нефтийн салбар, түүний дотор нефтийн бүтээгдэхүүний бөөний болон жижиглэнгийн худалдаа, хангамжийн бизнест үйл ажиллагаа явуулж ирсэн түүхэн туршлага, гүйцэтгэж буй үүргийг батлах чадавхийн талаархи мэдэгдэл.

Тендерт оролцох буй компанийг үүсгэн байгуулж, бүртгүүлсэн тухай баримт бичгүүд.

Хамгийн сүүлийн санхүүгийн жилийн эцсийн байдлаар гаргаж, аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан тэнцэл буюу хувьцаат компанийн хувьд хувьцаа эзэмшигчдэд зориулсан жилийн тайлан /консорциумаар оролцож байгаа тохиолдолд энэхүү мэдээллийг консорциумын гишүүн тус бүрээр гаргаж өгнө/.

Өргөдөл гаргагч компанийн нийт гаргасан хувьцааны 5 /тав/-аас дээш хувийг эзэмшиж буй гол хувьцаа эзэмшигчдийн жагсаалт / консорциумаар оролцож байгаа тохиолдолд энэхүү мэдээллийг консорциумын гишүүн тус бүрээр гаргаж өгнө/.

Тендерт консорциумын хэлбэрээр оролцох тохиолдолд консорциумын гишүүдийн хооронд байгуулсан гэрээ, гаргасан шийдвэрийн баталгаа.

Өргөдөл болон нууцгүй хадгалах тухай гэрээний загварыг интернет дахь Төрийн өмчийн хорооны [www.spc.gov.mn](http://www.spc.gov.mn) вэб хуудаснаас буюу энэхүү зар мэдээний ард бичигдсэн хаягаар авч болно.

Тендерийн хураамжийг Төрийн өмчийн хорооны дараахь дансанд төлнө:

|                              |  |
|------------------------------|--|
| Банкны нэр:                  | Монгол Улсын "Монголбанк" BOMJMNUB                 |
| SWIFT код:                   | Төрийн өмчийн хороо                                |
| Дансны нэр:                  | 3332404  |
| Дансны дугаар:               |  |
| Монголбанкны харилцагч банк: | Federal Reserve Bank of New York, NY, USA FRNYUS33 |
| SWIFT код:                   | Монголбанк   |
| Дансны нэр:                  | 021088506  |
| Дансны дугаар:               |  |

Тендерт оролцогч тендерт өөрийгөө төлөөлүүлэн оролцуулахаар итгэмжлэгдсэн төлөөлөгч томилж, төлөөлөх эрхийг зохиж журмын дагуу бичгээр үйлдсэн итгэмжлэлээр баталгаажуулна. Тендерт хэд хэдэн хуулийн этгээд хамтарч консорциумын хэлбэрээр оролцож байгаа бол тэд зөвхөн нэг итгэмжлэгдсэн төлөөлөгчийг томилж, тендерт нэг оролцогч болж оролцоно.

Тендерт оролцох хүсэлтэй илэрхийлсэн өргөдлийг 2003 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн (Улаанбаатарын цагаар) 18.00 цагаас өмнө ТӨХ-нд ирүүлнэ.

### Урьдчилан шалгаруулах үзүүлэлт

Өргөдөл гаргагч нь тендерт оролцох эрхтэй болж, тендерийн баримт бичгүүдийг хүлээж авахын тулд нефть, нефтийн бүтээгдэхүүний салбарын хөрөнгө оруулагч, эсвэл нефть, нефтийн бүтээгдэхүүний салбарын хөрөнгө оруулагчийн оролцоотой консорциум байхын зэрэгцээ дор дурдсан шаардлагыг хангасан байвал зонхино. Үүнд:

1. Нефтийн салбар, түүний дотор нефтийн бүтээгдэхүүний бөөний болон/буюу жижиглэнгийн худалдаанд хүлээн зөвшөөрөгдсөн туршлага хуримтлуулсан байх.
2. Санхүүгийн байдал нь тогтвортой, үйл ажиллагааны баялаг туршлагатай байх / үүнийг аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан тэнцлээр нотолно/.

### Урьдчилан шалгаруулалтын үр дүнг мэдээлэх

ТӨХ өргөдөл хүлээн авснаас хойш ажлын 10 /арван/ хоногийн дотор урьдчилан шалгаруулалтын шалгуурыг ханган тендерт оролцох эрхтэй болж, тендерийн баримт бичгүүдийг авах болсон эсэх талаар өргөдөл гаргагчид мэдэгдэнэ. Энэхүү мэдэгдлийг бичгээр үйлдэн

буухиа шуудан, баталгаат захиа, факс буюу электрон шуудангаар явуулна.

Урьдчилан шалгаруулалтын шалгуурыг хангасан тендэрт оролцогчдод мэдэгдлийг тендерийн баримт бичгийн хамт буухиа шуудангаар хүргүүлнэ.

Тендерийн баримт бичиг  
Тендерийн баримт бичиг гэдэгт дараахь иж бүрдлийг ойлгоно:

- 1/Ерөнхий мэдээлэл,
- 2/Уралдаант шалгаруулалт /тендер/-ын журам,
- 3/Хувьцаа худалдах, худалдан авах тухай гэрээний төсөл.

Хувьчлалын зорилго  
НИК ХК-ийг худалдаж авах сонирхолтой стратегийн хөрөнгө оруулагчид Засгийн газраас дэвшүүлж буй дор дурдсан хувьчлалын зорилгыг хангах бизнесийн стратеги болон үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, тендерийн саналтай хамт ирүүлэх шаардлагатай. Үүнд:  
Компанийн үйл ажиллагааны үндсэн чиглэл болох боловсруулсан нефтийн бүтээгдэхүүний импорт, хангамжийн үйл ажиллагааг хэвээр үлдээж, цаашид өргөжүүлэх.  
Нефтийн бүтээгдэхүүний хангамжийн эх үүсвэрийг бизнесийн тогтсон туршлагатай уялдуулан өргөжүүлж, найдвартай болгох, бага өртөг бүхий хангамжийн сүлжээг бий болгох, чанартай бүтээгдэхүүн, үйлчилгээний хангамжийг нэмэгдүүлэх.  
Аюулгүй ажиллагаа, байгаль орчны аюулгүй байдал, нефтийн бүтээгдэхүүний технологи, хадгаламжийн бааз болон шатахуун түгээх станцын стандартад тавих хяналтыг сайжруулах тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлэх.  
Компанийн барилга байгууламж, шатахуун түгээх станц, нефть хангамжийн баазуудыг шинэчлэх болон түүнийг олон улсын стандартад хүргэхэд чиглэгдсэн хөрөнгө оруулалт хийх.

## Тендерийн ажиллагаа

Тендэрт оролцогчид техникийн болон санхүүгийн саналаас бүрдэх тендерийн саналаа тендерийн дэнчин төлснийг нотлох баримтын хамт 2004 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн (Улаанбаатарын цагаар) 18.00 цагаас өмнө Төрийн өмчийн хороонд ирүүлнэ.

**"Дэнчин"** гэж хувьцаа худалдах, худалдан авах тухай гэрээг дуусгаар болгох үүрэг хүлээж буйгаа болон санхүүгийн эх үүсвэртэй болохоо батлан тендэрт оролцогчоос төлөх 100000 /нэг зуун мянган/ ам. доллартай тэнцэх хүүгүй мөнгөн хадгаламжийг хэлнэ. Тендэрт оролцогчид дэнчинг Монгол Улсын "Монголбанк" дахь ТӨХ-ны 3332404 дугаартай валютын дансанд төлнө.

Тендерийн саналыг үнэлсний дараа, тендэрт оролцогч ялагчаар шалгаргаагүй тохиолдолд тендерийн дэнчинг тендэрт оролцогчийн хууцэлтийн дагуу ажлын долоон /7/ өдөрт багтаан бүрэн буцаан олгох бөгөөд хууцэлтэд дэнчинг шилжүүлэх банкны дансны дугаарыг тодорхой заана.

Ялагчаар шалгарсан тендэрт оролцогчийн дэнчинг худалдан авах үнэд оролцуулан тооцно.

Тендерийн саналаа бэлтгэхэд нь туслах зорилгоор тендэрт оролцогчдыг Засгийн газрын холбогдох албан тушаалтан болон компанийн удирдлагатай уулзах, газар дээр нь танилцах бололцоогоор хангана. Тендэрт оролцогчдыг худалдах, худалдан авах гэрээний төсөлд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай санал гаргах бололцоогоор хангана.

Тендерийн саналыг дараахь байдлаар үнэлнэ:

1. Тухайн салбарт үйл ажиллагаа явуулж ирсэн туршлага болон түүхэн замнал (0-40 оноо),
2. Санал болгож буй бизнесийн стратеги/үйл ажиллагааны төлөвлөгөөний чанар, Засгийн газраас дэвшүүлж буй хувьчлалын зорилгыг хүлээн авч тусгасан байдал (0-60 оноо).

## Дэд үзүүлэлт:

- Бизнесийн төлөвлөгөөний цар хүрээ, тодорхой байдал (0-10 оноо),
- Төлөвлөгөө, стратеги нь Засгийн газраас дэвшүүлж буй зорилгод нийцсэн байдал (0-20 оноо),
- Компанийн одоо ашиглагдаж буй барилга байгууламж, шатахуун түгээх станц, нефть хангамжийн баазуудыг шинэчлэх, түүний хугацаа, өртөг зардлын бүтэц зэргийг хамруулсан техникийн шинэчлэл хийх хөрөнгө оруулалтын төлөвлөгөө (0-10 оноо),
- Байгаль орчныг хамгаалах, аюулгүй байдлыг хангах төлөвлөгөө (0-10 оноо),
- Ажиллагсдад сургалт явуулах хөтөлбөрийг тусгасан хүний нөөцийг хөгжүүлэхэд оруулах хөрөнгө оруулалтын хэмжээ, төрөл зэрэг хүний нөөцийг хөгжүүлэх төлөвлөгөө (0-10 оноо).

Техникийн үнэлгээгээр 70-аас доошгүй оноо авсан саналыг шалгаруулна.

Санхүүгийн санал нь компанийн тендерээр худалдаалагдаж буй хувьцааг худалдан авахаар тендэрт оролцогчоос санал болгож буй үнээс бүрдэнэ. Худалдан авах үнийн шаардлага хангахын тулд НИК ХК-ийн төрийн эзэмшлийн багц хувьцааг **худалдан авахаар санал болгож буй үнэ нь 6133000 /зургаан сая нэг зуун гучин гурван мянган/ ам. доллараас доошгүй байна.**

Техникийн үнэлгээгээр авбал зохих доод онооны болзлыг ханган тэнцсэн, санхүүгийн саналдаа худалдан авах хамгийн өндөр үнийн саналыг ирүүлсэн оролцогчийг тендерийн ялагчаар шалгаруулна.

## "НИК" ХК-ийн тухай

"НИК" ХК нь 1941 онд Монголын үндэсний нефть хангамжийн байгууллага нэртэйгээр анх байгуулагдсан бөгөөд Монгол Улсын Засгийн газрын Өмч хувьчлалын комиссын 1994 оны 5 дугаар сарын 6-ны өдрийн 7 дугаар тогтоолоор нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 20,950,960 ширхэг хувьцаа бүхий хувьцаат компани болгон өөрчлөн зохион байгуулж, нийт хувьцааны 80%-ийг төрийн мэдэлд үлдээжээ. Үлдэх 20% нь Монголын хөрөнгийн бирж дээр арилжаалагддаг. Нэгж хувьцааны сарын дундаж ханш 2002 оны 5 дугаар сарын байдлаар 162 төгрөг байсан. "НИК" ХК-ийн хувьцааны зах зээлийн үнийн дүн нь 2002 оны 5 дугаар сарын байдлаар 3.4 тэрбум төгрөг болж байсан бөгөөд тус компани нь хөрөнгийн зах зээл дээр гуравт орж байна.

"НИК" ХК нь Монгол Улсын нефть импорт хангамжийн үндэсний хамгийн том компанийн нэг бөгөөд 2002 оны жилийн эцсийн байдлаар боловсруулсан нефтийн бүтээгдэхүүний дотоодын зах зээлийн 19%-ийг эзэлж байжээ. Компанийн үйл ажиллагааны үндсэн чиглэл нь бүх төрлийн шатахуун, дизель түлш, онгоцны түлш, тосолгооны материал зэрэг боловсруулсан нефтийн бүтээгдэхүүний импорт ба борлуулалт юм. Үүнээс гадна шингэрүүлсэн хийн импорт ба борлуулалт, нефтийн байгууллагуудын техник, тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийн хангамж зэрэг бусад чиглэлийн ажил, үйлчилгээ эрхэлдэг. Улсын хэмжээнд 21 аймаг болон 300 гаруй сум бүрт салбартай, бүс нутгийн 22 нефть хангамжийн бааз болон 402 шатахуун түгээх станцуудаас бүрдсэн үндэсний хэмжээнд хангамжийн сүлжээтэй цорын ганц компани юм.

Монгол Улсын Засгийн газар "НИК" ХК-ийг худалдаа, арилжааны үйл ажиллагаанаас гадна улс орны өнцөг булан бүрийг шатахуунаар тасралтгүй хангах үүрэг бүхий стратегийн объект гэж үздэг.

Импортлосон нефтийн бүтээгдэхүүнийг төмөр зам болон ачааны автомашинаар нефть хангамжийн 7 үндсэн баазад нийлүүлж, тэндээсээ туслах бааз болон аймгийн хангамжийн баазуудад хуваарилан ачааны машинаар тээвэрлэдэг. "НИК" ХК-ийн баазууд нь нийтдээ 290,245 м<sup>3</sup> хадгалах бодит хүчин чадалтай. Тус компани нь нефтийн бүтээгдэхүүнийг бүс нутгийн хангамжийн бааз болон ШТС-ууд руу тээвэрлэх зориулалттай 219 автоцистерн болон 200 чиргүүлээс бүрдсэн тээврийн хэрэгслийн паркттай. Өөрийн тээврийн хэрэгслээс гадна хувийн тээврийн компаниудтай гэрээ байгуулж, дотоодын тээвэрлэлтийнхээ тодорхой хувийг хангадаг.

"НИК" ХК нь 100%-ийн хөрөнгө оруулалттай хоёр охин компанитай.

- "НИК-Газ" ХХК: Тосолгооны материал ба шингэрүүлсэн хийн импорт, борлуулалт эрхэлдэг. Мөн дурмийн дагуу түүхий газрын тосны хайгуул, олборлолт, боловсруулалт эрхлэх бололцоотой.
- "НИК-Аян" ХХК: Нефть хангамжийн бааз болон бусад байгууламжийн барилга засварын ажил гүйцэтгэдэг.
- "НИК" ХК нь гурван хамтарсан компанид хувь эзэмшдэг. Үүнд:

Нефтийн бүтээгдэхүүний хадгалалт эрхлэх зорилгоор Монголын хоёр хувийн компанитай хамтран байгуулсан 513.4 сая төгрөгийн дүрмийн сантай "МП" ХХК-ийн 49%-ийг эзэмшдэг.

АНУ-аас нефтийн тоног төхөөрөмж импортлох үйл ажиллагаа явуулдаг "Флоко Си Эй" ХХК-ийн 40%-ийг эзэмшдэг.

"НТТ" (Нефть Транзит Трейдинг) ХХК-ийн 30%-ийг эзэмшдэг. Энэ хамтарсан компани нь ОХУ-д бүртгэлтэй бөгөөд тус улсаас Монгол Улсын хил дээрх дамжуулан өнгөрүүлэх хоёр бааз хүртэл нефть бүтээгдэхүүнийг тээвэрлэх үйл ажиллагаа явуулдаг.

"НИК" ХК нь нефть бүтээгдэхүүнийхээ 90 орчим хувийг ОХУ, 6 орчим хувийг БНХАУ, үлдэх хувийг Солонгос Улсаас тус тус импортлодог.

Тус компани 2002 оны эхний гурван улирлын байдлаар 67.3 мянган тонн нефть бүтээгдэхүүн борлуулсан.

2001 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан тэнцлээр компанийн нийт хөрөнгө 50.7 тэрбум төгрөг, үүнээс эргэлтэн хөрөнгө 27.3 тэрбум төгрөг, цэвэр үндсэн хөрөнгө 22.0 тэрбум төгрөг, хөрөнгө оруулалт 0.7 тэрбум төгрөг байна. Үндсэн хөрөнгийн 63.3 хувийг барилга, байгууламж, машин, тоног төхөөрөмж эзэлдэг.

Тус компани нь 2001 онд 1.2 тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан байна. 2000 оны цэвэр борлуулалтын дүн 49,252 сая төгрөг байсан бол 2001 онд 47,358 сая төгрөг болж буурсан. ОХУ-ын боловсруулах үйлдвэрүүдээс нийлүүлэх нефть бүтээгдэхүүний хэмжээг хязгаарлаж, төгрөгийн ам. доллартай харьцах ханш өсч, дэлхийн зах зээлд дээрх нефтийн үнэ өссөнтэй уялдуулан дотоодын зах зээлийн үнийг зохицуулаагүйгээс компанийн ашигт ажиллагааны түвшин 1999-2000 онд эрс буурсан.

Засгийн газрын 2003 оны 1 дүгээр сарын 22-ны өдрийн 19 дүгээр тогтоолын дагуу "НИК" хувьцаат компанийн нийт хувьцааны 80 хувьд ногдох төрийн эзэмшлийн багц хувьцааг худалдан авах үнийг бүрэн төлвөл Засгийн газарт компаниас төлөх 7413978000 /долоон тэрбум дөрвөн зуун арван гурван сая өсөн зуун далан найман мянган/ төгрөгийн өрийг Засгийн газар өршөөж, компанийн энэ өрөөс чөлөөлнө. Үүнээс гадна 12,020,522,000 төгрөгийн өрийг "НИК" хувьцаат компаниас төрийн байгууллагуудад шилжүүлсэн хөрөнгө болон улсын нөөцийн нефтийн бүтээгдэхүүнийг татан авах, шинэчлэх, хадгалах үйл ажиллагаанд 1991-1998 онд гаргасан зардлаар хаахаар шийдвэрлэсэн юм.

"НИК" ХК нь газар ашиглах гэрээний үндсэн дээр газар эзэмшдэг. Гэрээгээр ашиглах газрын нийт хэмжээ нь 540 гектар. Гэрээг 3-60 жилийн хугацаатай байгуулдаг. Газрын түрээсийн жилийн нийт төлбөр нь 139,818,000 төгрөг.

"НИК" ХК-ийн сүүлийн дөрвөн жилийн санхүүгийн тайлан тэнцлийн үзүүлэлтүүдийг дараахь хүснэгтээр үзүүлэв:

## САНХҮҮГИЙН ТАЙЛАН ТЭНЦЛИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

### БАЛАНС

(мянган төгрөгөөр)

| 12 дугаар сарын 31-ний байдлаар                 | 1998              | 1999              | 2000              | 2001              | 2002*             |
|---|-------------------|-------------------|-------------------|-------------------|-------------------|
| Нийт эргэлтийн хөрөнгө                          | 27 729 374        | 26 127 343        | 26 984 454        | 21 223 851        | 28,470,499        |
| Нийт эргэлтийн бус хөрөнгө                      | 16 291 635        | 26 695 005        | 25 061 051        | 23 076 761        | 22,190,144        |
| <b>I. Нийт хөрөнгө</b>                          | <b>44 021 008</b> | <b>52 822 348</b> | <b>52 045 505</b> | <b>44 300 612</b> | <b>50,660,643</b> |
| II. Нийт богино хугацаат өр                     | 17 001 467        | 15 037 657        | 18 847 058        | 20 511            | 21,320,268        |
| III. Нийт урт хугацаат өр                       | 695 503           | 695 503           |                   | 695 503           | 1,787,328         |
| <b>IV. Нийт өр төлбөр</b>                       | <b>17 696 970</b> | <b>15 733 160</b> | <b>18 847 058</b> | <b>21 207 201</b> | <b>23,107,596</b> |
| V. Нийт эзэмшигчийн өмч                         | 26 324 038        | 37 089 187        | 33 198 446        | 23 093 411        | 27,553,047        |
| <b>VI. Нийт өр төлбөр болон эзэмшигчийн өмч</b> | <b>44 021 008</b> | <b>52 822 348</b> | <b>52 045 505</b> | <b>44 300 612</b> | <b>50,660,643</b> |

### ОРЛОГО, ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

| 12 дугаар сарын 31-ний байдлаар          | 1998              | 1999              | 2000              | 2001               | 2002*             |
|--|-------------------|-------------------|-------------------|--------------------|-------------------|
| <b>Цэвэр борлуулалтын орлого</b>         | <b>68 147 545</b> | <b>47 539 439</b> | <b>49 251 964</b> | <b>47 358 413</b>  | <b>30,218,307</b> |
| Үйл ажиллагааны бус орлого               | 298 822           | 1 646 620         | 187 407           | 353 099            | 871,445           |
| Нийт зардал                              | 61 590 236        | 47 829 759        | 48 553 684        | 56 555 862         | 30,730,576        |
| <b>Ердийн үйл ажиллагааны орлого</b>     | <b>6 856 131</b>  | <b>1 356 301</b>  | <b>885 687</b>    | <b>(8 844 350)</b> | <b>359,177</b>    |
| Үндсэн үйл ажиллагааны бус орлого/зардал | (15 919)          | 669               | 9 488             | (820 811)          | 1,406             |
| <b>Орлогын татварын өмнөх ашиг</b>       | <b>6 840 212</b>  | <b>1 356 970</b>  | <b>895 175</b>    | <b>(9 665 161)</b> | <b>360,583</b>    |
| Орлогын татвар                           | 3 335 392         | 1 254 786         | 855 214           | 7 824              | 307,371           |
| <b>Цэвэр ашиг</b>                        | <b>3 504 850</b>  | <b>102 184</b>    | <b>39 961</b>     | <b>(9 672 985)</b> | <b>53,211</b>     |

\*Тайлбар: 2002 оны 9 дүгээр сарын 30-ны байдлаар

Тендэрт оролцох өргөдөл, тендерийн саналыг дор дурдсан хаягаар ТӨХ-нд ирүүлнэ:

Л. Пүрэвдорж  
 Төрийн өмчийн хорооны дарга  
 Засгийн газрын 4-р байр, 410-р өрөө  
 Улаанбаатар-11, Монгол Улс  
 Утас: 976-11-312460  
 Факс: 976-11-312798

Нэмэлт мэдээлэл авах эсхүл тодруулах зүйл байвал Төрийн өмчийн хорооны дээрх хаягаар эсхүл ТӨХ-ны зөвлөх Бэринг Пойнт ХХК-ийн Барентс бүлгийн дор дурдсан хүмүүстэй холбоо барина уу:

Бэринг Пойнт ХХК-ийн Барентс бүлэг  
Засгийн газрын 11-р байр, 301-р өрөө  
Улаанбаатар-38  
Монгол улс  
Утас: 976-11-324149  
Факс: 976-11-324149  
 Э-шуудан: [barents@magicnet.mn](mailto:barents@magicnet.mn)

Тереза Слзас  
 Төслийн удирдагчийн орлогч  
 Э-шуудан:  
[tslzas@bearingpoint.net](mailto:tslzas@bearingpoint.net)

Д. Ашидмаа  
 Зөвлөх  
 Э-шуудан:  
[dashnyam@mongol.net](mailto:dashnyam@mongol.net)

Живко Ненов  
 Төслийн удирдагч  
 Э-шуудан:  
[znenov@magicnet.mn](mailto:znenov@magicnet.mn)



## Эсхүл

Тереза Спласас  
 Barents Group of Bearing Point, Inc.  
 1676 International Drive  
 McLean, VA 22102, USA  
 Tel: +1 703-747-7698  
 Fax: +1 703-747-3919  
 E-mail: [tslazas@bearingpoint.net](mailto:tslazas@bearingpoint.net)

Компанитай холбоотой мэдээлэл болон зарлалыг <http://www.spc.gov.mn> вэбсайтаас үзнэ үү.

### Засгийн газрын 2003 оны 215 дугаар тогтоолын 2 дугаар хэвсрэлт

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР ТӨРИЙН ӨМЧИЙН ХОРОО

### УРАЛДААНТ ШАЛГАРУУЛАЛТ /ТЕНДЕР/-ЫН ЖУРАМ

#### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Монгол Улсын "Иргэний хууль", "Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль", Монгол Улсын Их Хурлын 2001 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 10 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн өмчийг 2001-2004 онд хувьчлах үндсэн чиглэл", Засгийн газрын 2002 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн 9 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн өмчийг 2002 онд хувьчлах хөтөлбөр"-ийн дагуу "НИК" хувьцаат компани /цаашид "НИК" ХК эсвэл "компани" гэх/-ийн нийт хувьцааны 80 /наяа/ хувьд ногдох төрийн эзэмшлийн 16760768 /арван зургаан сая долоон зуун жаран мянга долоон зуун жаран найман / ширхэг энгийн хувьцаа /цаашид "хувьцаа" гэх/-г уралдаант шалгаруулалт /тендер/-ын аргаар гадаадын буюу дотоодын стратегийн хөрөнгө оруулагчдад худалдахад энэхүү журам /цаашид "журам" гэх/-ыг мөрдөнө.

1.2. Төрийн өмчийн хороо нь зөвлөхүүдийн туслалцаатайгаар тендерийг зохион байгуулж явуулна.

#### Хоёр. Нэр томъёоны тодорхойлолт

Энэхүү журамд хэрэглэсэн нэр томъёог дор дурдсанаар тодорхойлно:

2.1. "**Компани**" гэж "НИК" хувьцаат компанийг хэлнэ.

2.2. "**Стратегийн хөрөнгө оруулагч**" гэж нефтийн салбарт, түүний дотор нефтийн бүтээгдэхүүний бөөний болон/буюу жижиглэнгийн худалдаанд хүлээн зөвшөөрөгдсөн туршлага хуримтлуулж ирсэн гадаадын буюу дотоодын нефть, нефтийн бүтээгдэхүүний салбарын хөрөнгө оруулагч /гадаадын буюу дотоодын хуулийн этгээд/ эсхүл нефть, нефтийн бүтээгдэхүүний салбарын хөрөнгө оруулагчийн оролцоотой консорциумыг хэлнэ.

2.3. "**Зар мэдээ**" гэж Төрийн өмчийн хорооноос тендер явуулах тухай нийтэд сонордуулсан албан ёсны зар мэдээллийг хэлнэ.

2.4. "**Уралдаант шалгаруулалт** /цаашид "тендер" гэх/" гэж тендер оролцогчоос ирүүлсэн тендерийн саналуудыг хянан үзэж, ялагчийг тодруулан, түүнтэй хувьцаа худалдах, худалдан авах тухай гэрээ байгуулах үйл ажиллагааг хэлнэ.

2.5. "**Өргөдөл**" гэдэгт тендер оролцогчоос ирүүлэх өргөдөл, өргөдөл гаргагчийн

итгэмжлэгдсэн төлөөлөгч гарын үсэг зурсан нууцыг хадгалах тухай гэрээ болон тендерийн хураамж төлснийг нотлох баримтын иж бүрдлийг ойлгоно. Итгэмжлэгдсэн төлөөлөгчийн төлөөлөх эрхийг зохих журмын дагуу бичгээр үйлдэж өргөдөлд хавсаргасан итгэмжлэлээр баталгаажуулна. Өргөдөл гаргагч тендерийн оролцогч болохын тулд урьдчилан шалгаруулалтад шаардагдах өөрийн компанийн болон консорциумын талаархи мэдээллийг өргөдөлд хавсаргасан байна.

2.6. "**Нууцыг хадгалах тухай гэрээ**" гэж компани, Төрийн өмчийн хороо, Монгол Улсын Засгийн газар болон зөвлөхүүдээс өгөх компанитай холбоотой аливаа мэдээллийг ямар нэгэн хэлбэрээр тараах болон мэдээлэхийг хориглосон гэрээг хэлнэ.

2.7. "**Тендерийн хураамж**" гэж тендерийн баримт бичгээр хангах үйлчилгээний хураамж болон тендер оролцогчоос Төрийн өмчийн хороонд төлөх 1000 /нэг мянган/ ам. долларын үл буцаах төлбөрийг хэлнэ.

2.8. "**Тендерт оролцогч**" гэж тендерт оролцохоор өргөдөл гаргаж, урьдчилан шалгаруулалтын шаардлагыг ханган, Төрийн өмчийн хороо өргөдлийг нь хүлээн авсан хуулийн этгээд буюу тэдгээрийн хамтарсан консорциумыг хэлнэ.

2.9. "**Тендерийн баримт бичиг**" гэдэгт:

- 1) Уралдаант шалгаруулалт /тендер/-ын журам,
- 2) Ерөнхий мэдээлэл,
- 3) Хувьцаа худалдах, худалдан авах тухай гэрээний төслийн иж бүрдлийг ойлгоно.

2.10. "**Ерөнхий мэдээлэл**" гэж тендерт оролцогч тус бүрт хүргэж компани болон Монгол улс, түүний бизнесийн орчны талаархи мэдээлэл бүхий баримт бичгийг хэлнэ.

2.11. "**Дэнчин**" гэж хувьцаа худалдах, худалдан авах тухай гэрээг дуусгавар болгох үүрэг хүлээж буйгаа болон санхүүгийн эх үүсвэртэй болохоо батлан тендерт оролцогчоос төлөх 100000 /нэг зуун мянган/ ам. доллартай тэнцэх хүүгийг мөнгөн хадгаламжийг хэлнэ. Дэнчинг Монгол Улсын Монголбанк дахь Төрийн өмчийн хорооны валютын дансанд төлнө.

2.12. "**Тендерийн санал**" гэж тендерт оролцогчоос компанийн хувьцааг худалдан авахаар



ирүүлсэн саналыг хэлнэ. Тендерийн санал нь техникийн ба санхүүгийн саналаас бүрдсэн байна.

2.13. **"Худалдан авах үнэ"** гэж тендерээр худалдаалагдах буй компанийн хувьцааг худалдан авахаар тендерт оролцогчоос санал болгож буй үнийн дүнг хэлнэ. "НИК" хувьцаат компанийн нийт хувьцааны 80 хувьд ногдох төрийн эзэмшлийн багц хувьцааг худалдан авах 6133000 /зургаан сая нэг зуун гучин гурван мянган/ ам. доллараас доошгүй үнийг бүрэн төлвөл Санхүү, эдийн засгийн яаманд компаниас төлөх 7413978000 /долоон тэрбум дөрвөн зуун арван гурван сая есөн зуун далан найман мянган/ төгрөгийн тусламжийн барааны өрийг Засгийн газар өршөөж, компанийг энэ өрөөс чөлөөлнө.

2.14. **"Хувьцаа худалдах, худалдан авах тухай гэрээний төсөл"** гэж Төрийн өмчийн хорооноос санал болгож буй, тендерт оролцогчдын саналыг авахаар хүргүүлэх хувьцаа худалдах, худалдан авах гэрээний төслийн эхний хувилбарыг хэлнэ.

2.15. **"Хувьцаа худалдах, худалдан авах тухай гэрээний шинэчилсэн төсөл"** гэж хувьцаа худалдах, худалдан авах тухай гэрээний төслийн эхний хувилбарт тендерт оролцогчдын өгсөн саналыг тусгасан шинэчилсэн хувилбарыг хэлнэ.

2.16. **"Хувьцаа худалдах, худалдан авах тухай гэрээний эцсийн төсөл"** гэж хувьцаа худалдах, худалдан авах тухай гэрээний шинэчилсэн төсөлд тендерт оролцогчдоос санал болгосон нэмэлт өөрчлөлтөөс хүлээн авч болохуйц саналуудыг тусган Төрийн өмчийн хорооноос эцэслэн бэлтгэж гаргах төслийг хэлнэ.

2.17. **"Зөвлөх"** гэж Америкийн Нэгдсэн Улсын Олон улсын хөгжлийн агентлагийн тусламжтайгаар Төрийн өмчийн хороонд зөвлөх үйлчилгээ үзүүлж буй Бэринг Пойнт ХХК-ийн Бренц бүлгийн зөвлөхүүдийг хэлнэ.

## Гурав. Тендерийн хуваарь

3.1. Тендерийг энэхүү журамд хавсаргасан хуваарийн дагуу зохион байгуулж явуулна /Хавсралт 1/.

## Дөрөв. Тендерт оролцогч

### 4.1. Тендерт оролцогчийн эрх зүйн байдал

4.1.1. Урьдчилан шалгаруулалтад тэнцсэн, Монгол Улсын болон гадаад улсын нефть, нефтийн бүтээгдэхүүний салбарын хөрөнгө оруулагч эсхүл нефть, нефтийн бүтээгдэхүүний салбарын хөрөнгө оруулагчийн оролцоотой консорциум зэрэг урьдчилан шалгаруулах шатны үнэлгээний шаардлагыг хангасан бүх боломжит хөрөнгө оруулагчид тендерт оролцож болно.

4.1.2. Тендерт оролцогч тендерт өөрийгөө төлөөлүүлэн оролцуулахаар итгэмжлэгдсэн төлөөлөгч томилж, төлөөлөх эрхийг зохих журмын дагуу бичгээр үйлдсэн итгэмжлэлээр баталгаажуулна.

4.1.3. Тендерт хэд хэдэн хуулийн этгээд хамтарч консорциумын хэлбэрээр оролцож байгаа

бол тэд зөвхөн нэг /1/ итгэмжлэгдсэн төлөөлөгчийг томилж, тендерт нэг оролцогч болж оролцоно.

### 4.2. Тендерт оролцогчийн эрх

4.2.1. Тендерт оролцогч нь тендерт оролцох өргөдлөө ирүүлж, урьдчилан шалгаруулалтад тэнцсэн тохиолдолд Төрийн өмчийн хорооноос баталж, тэмдэг дарсан тендерийн баримт бичгийн нэг иж бүрэн багцыг авах эрхээр хангагдана.

4.2.2. Тендерт оролцогч нь дараахь эрх эдэлнэ:

- 1) Төрийн өмчийн хорооноос баталж гаргасан компанитай танилцах, дүн шинжилгээ, уулзалт хийх хуваарийн дагуу компанийн удирдлагатай уулзах, барилга байгууламжийг үзэх,
- 2) Төрийн өмчийн хорооноос бичгээр зөвшөөрөл авсны үндсэн дээр Монгол Улсын Засгийн газрын холбогдох албан тушаалтантай уулзах,
- 3) Энэхүү журам болон тендерийн үйл ажиллагаатай холбогдсон мэдээллийн талаар тайлбар авах зорилгоор компанийн хувьчлалын асуудлыг хариуцсан Төрийн өмчийн хорооны итгэмжлэгдсэн төлөөлөгчтэй уулзах,
- 4) Тайлбар авах хүсэлтийг англи буюу монгол хэл дээр үйлдэж Төрийн өмчийн хороонд дараахь хаягаар бичгээр ирүүлнэ:

Л. Пүрэвдорж

Төрийн өмчийн хорооны дарга  
Засгийн газрын IV байр, 410-р өрөө  
Улаанбаатар-11, Монгол Улс  
Утас: 976-11-312460  
Факс: 976-11-312798

Төрийн өмчийн хороо ирсэн бүх хүсэлтэд бичгээр хариулт өгөх бөгөөд асуулт, харуултын хувийг тендерт оролцогч бүрт тэдний өргөдөл дээр заасан хаягаар хүргүүлнэ. Ийнхүү хүргүүлэхдээ буухиа шуудан, баталгаат захиа, факс, эсхүл электрон шууданг ашиглаж болно.

Тендерийн санал авах хугацаа дуусахаас өмнөх ажлын таван /5/ хоногос хожимдуулж ирүүлсэн тайлбар авах хүсэлтийг Төрийн өмчийн хороо хүлээж авахгүй байж болно.

5) Монгол Улсын "Иргэний хууль", "Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль"-д заасан бусад эрх эдлэх.

### 4.3. Тендерт оролцогчийн үүрэг

Тендерт оролцогч нь дараахь үүрэгтэй:

- 1) Өөрийн бизнес, эрх зүй, санхүүгийн байдлын талаар үнэн зөв мэдээлэл өгөх,
- 2) Тендерт оролцох явцад өөрийн бизнес, эрх зүй, санхүүгийн байдалд гарсан, тендерт оролцоход нь нөлөөлж болзошгүй аливаа материаллаг

өөрчлөлтийн талаар Төрийн өмчийн хороонд нэн даруй мэдээлэх,

- 3) Компанийн хувьцааг худалдан авах талаар тендерийн бусад оролцогчидтой ямар нэгэн харилцаа холбоо тогтоох болон аливаа хэлбэрээр хэлэлцээрт орохгүй байх,
- 4) Компанитай байгуулсан буюу байгуулахаар төлөвлөж байгаа бизнесийн аливаа гэрээ, хэлэлцээрийн талаар Төрийн өмчийн хороонд бичгээр мэдэгдэх,
- 5) Тендерт оролцох буюу оролцохтой холбогдон гарах бүх зардлыг өөрөө хариуцах,
- 6) Монгол Улсын хууль тогтоомж болон энэхүү журмыг сахин биелүүлэх.

### Тав. Тендерийн баримт бичиг

5.1. Тендерт оролцогч тус бүрт тендерийн баримт бичгийн нэг иж бүрэн багцыг олгоно.

5.2. Төрийн өмчийн хорооноос олгох тендерийн баримт бичигт Төрийн өмчийн хорооны тэмдэг дарсан байна.

5.3. Төрийн өмчийн хороо болон зөвлөхүүд тендертэй холбоотой мэдээллийг тендерийн баримт бичигт оруулана. Энэхүү мэдээллийг ашиглахтай холбоотойгоор үүсч болох аливаа үүрэг, хариуцлагыг Төрийн өмчийн хороо болон зөвлөхүүдийн аль аль нь хүлээхгүй.

### Зургаа. Дүн шинжилгээ хийх

6.1. Тендерт оролцогчдыг тэдгээрийн хүсэлтийн дагуу Засгийн газрын холбогдох албан тушаалтан болон компанийн удирдлагатай уулзах, компанитай газар дээр нь танилцах бололцоогоор хангана.

6.2. Тендерт оролцогчдод тендерийн саналаа ирүүлэхээс өмнө компани дээр очиж компанийн хөрөнгө, өр төлбөрийн талаар нарийвчилсан дүн шинжилгээ хийх, өөрсдийн саналаа хэлэх, Засгийн газраас дэвшүүлж буй хувьчлалын зорилгын талаар Төрийн өмчийн хорооны ажилтнуудтай болон зөвлөхүүдтэй ярилцах бололцоог олгоно. Төрийн өмчийн хороо тендерт оролцогч тус бүрт 2 /хоёр/ долоо хоног хүртэл хугацаагаар компани дээр очиж түүний үйл ажиллагаанд нарийвчилсан дүн шинжилгээ хийх хуваарь гаргах ба оролцогч хүсэлт гаргасан тохиолдолд Төрийн өмчийн хороо өөрийн үзэмжээр нэмэлт хугацаа олгоно. Дүн шинжилгээний хугацаанд тендерт оролцогчид компанийн удирдлага, ажилтнуудтай уулзах өргөн боломжоор хангагдах бөгөөд компанийн бүртгэл, баримт, түүнчлэн компьютерийн систем, конторын болон бусад барилга байгууламжийн байдал болон өөрсдийн сонирхсон хүрээнд аливаа бусад асуудлыг судлах эрхээр хангагдана.

6.3. Төрийн өмчийн хороо нь компани дээр очиж дүн шинжилгээ хийх хуваарийг хүсэлт хүлээж авсан дарааллаар гаргаж, тендерт оролцогчдод энэ тухай факс буюу электрон шуудангаар мэдэгдэнэ.

6.4. Тендерт оролцогч нь тендерийн саналаа ирүүлснээр компанийн нөхцөл байдал, үйл ажиллагаатай танилцаж, улмаар эдгээрийг зөвшөөрч, Төрийн өмчийн хорооноос буюу түүний өмнөөс компанийн талаар гаргаж өгсөн бүх

мэдээллийн үнэн зөв болохыг албан ёсоор хүлээн зөвшөөрсөнд тооцогдоно. Байгаа мэдээлэл, бодит байдалтай танилцаж чадаагүй тендерт оролцогч нь тендерийн санал, хувьцаа худалдах, худалдан авах тухай гэрээний төслийг боловсруулах үүрэгээс чөлөөлөгдөхгүй. Төрийн өмчийн хороо, түүний зөвлөх, компани, эдгээрийн төлөөлөгчдөөс гаргаж өгсөн мэдээлэлд үндэслэн тендерт оролцогчийн зүгээс гаргасан дүгнэлт, тайлбарын талаар Төрийн өмчийн хороо, түүний зөвлөх, шинжээчдийн баг, компани, эдгээрийн төлөөлөгчдийн аль аль нь хариуцлага хүлээхгүй.

6.5. Тендерт оролцогч компанитай танилцах, дүн шинжилгээ болон уулзалт хийхгүй байхаар шийдвэрлэсэн тохиолдолд ч тендерийн санал өгөх эрхтэй хэвээр үлдэнэ.

### Долоо. Хувьцаа худалдах, худалдан авах тухай гэрээний төслийг эцэслэн боловсруулах

7.1. Тендерт оролцогчдоос санал болгож 2003 оны 12 дугаар сарын 9-ний дотор Төрийн өмчийн хороонд ирүүлсэн нэмэлт, өөрчлөлтүүд дээр үндэслэн Төрийн өмчийн хороо хувьцаа худалдах, худалдан авах тухай гэрээний төсөлд нэмэлт, өөрчлөлт оруулж, уг гэрээний шинэчилсэн төслийг боловсруулж болно.

7.2. Төрийн өмчийн хороо хувьцаа худалдах, худалдан авах тухай гэрээний шинэчилсэн төслийг боловсруулсан тохиолдолд энэ тухай тендерт оролцогч тус бүрт мэдэгдэж, шинэчилсэн төслийн хувийг 2003 оны 12 дугаар сарын 23-ны дотор тараана.

7.3. Тендерт оролцогчдод хувьцаа худалдах, худалдан авах тухай гэрээний шинэчилсэн төсөлд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай саналаа 2004 оны 1 дүгээр сарын 13-ны дотор ирүүлэхийг санал болгоно. Энэ өдрөөс хойш ирүүлсэн санал, тайлбарыг хүлээж авахгүй.

7.4. Тендерт оролцогчдоос хувьцаа худалдах, худалдан авах тухай гэрээний шинэчилсэн төсөлд оруулахаар санал болгосон нэмэлт, өөрчлөлтүүдийг үндэслэн Төрийн өмчийн хороо хувьцаа худалдах, худалдан авах тухай гэрээний эцсийн төслийг боловсруулж, тендерт оролцогч тус бүрт 2004 оны 1 дүгээр сарын 27-ны дотор тараана.

### Найм. Тендерийн санал бэлтгэх, санал ирүүлэхэд тавигдах ерөнхий шаардлага

8.1. Бүх мөнгөн дүнг Америкийн Нэгдсэн Улсын доллараар илэрхийлнэ.

8.2. Тендерт оролцогчид тендерийн саналын нэг /1/ эх хувь болон таван /5/ хуулбарыг ирүүлнэ.

8.3. Тендерт оролцогчид тендерийн саналыг англи буюу монгол хэлний аль нэг дээр бэлтгэж ирүүлнэ. Харин хувьцаа худалдах, худалдан авах гэрээний эцсийн төслийн гарын үсэг зурсан хоёр /2/ эх хувийг англи болон монгол хэл дээр бэлтгэж, техникийн саналын эх хувьд хавсарган ирүүлнэ.

8.4. Саналын эх хувь болон хуулбаруудын хооронд ямар нэгэн зөрүү гарах тохиолдолд эх хувийг баримтална.

8.5. Тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч тендерийн саналын эх хувьд хар буюу хөх өнгийн бэхээр гарын үсэг зурж, хуудас бүрийг үзэглэнэ. Итгэмжлэгдсэн төлөөлөгчид олгосон эрхийг зохих журмын дагуу бичгээр үйлдэн, тендерийн саналд хавсаргасан итгэмжлэлээр баталгаажуулна.

8.6. Тендерийн саналд оруулсан бүх засварт тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч гарын үсгээ зурах буюу үзэглэж баталгаажуулна.

8.7. Тендерийн саналыг шуудангаар ирүүлсэн тохиолдолд Төрийн өмчийн хороон дээр хүлээн авсан өдрийг тендерийн санал ирүүлсэн өдөр гэж тооцно.

8.8. Төрийн өмчийн хороо тендерийн саналыг хүлээж авсан огноо, цагийг тэмдэглэсэн баримтыг оролцогч тус бүрт илгээж хүлээн авснаа батална. Шуудангаар ирүүлсэн тендерийн саналын дугтуйн дээр хариу илгээх факсын дугаарыг заагаагүй тохиолдолд хүлээн авсан тухай баримтыг дугтуйн дээр хаягаар эсхүл тендерт оролцогчийн Төрийн өмчийн хорооны бүртгэлд тусгагдсан хаягаар илгээнэ.

8.9. Тендерт оролцогч нь тендерийн санал хүлээн авах хугацаа дуусахаас өмнө Төрийн өмчийн хороонд бичгээр мэдэгдэж, тендерийн саналаа өөрчлөх, эсхүл татан авах эрхтэй.

## Ес. Дэнчин

9.1. Тендерийн саналаа ирүүлэх хүсэлтэй тендерт оролцогчид Төрийн өмчийн хорооны дор дурдсан валютын харилцах дансанд 100000 /ног зуун мянган/ америк долларын дэнчин төлнө. Үүнд:

|                 |   |
|-----------------|---|
| Банкны нэр:     | Монгол Улсын<br>"Монголбанк"                    |
| SWIFT код:      | BOMUMNUB  |
| Дансны нэр:     | Төрийн өмчийн<br>хороо                          |
| Дансны дугаар:  | 3332404   |
| Харилцагч банк: | Federal Reserve<br>Bank of New York,<br>NY, USA |
| SWIFT код:      | FRNYUS33  |
| Дансны нэр:     | Монголбанк                                      |
| Дансны дугаар:  | 021088506                                       |

Дэнчин төлөхийг нотолсон банкны баримтын хуулбарыг техникийн саналд хавсаргана.

9.2. Тендерт оролцогч нь дэнчин тавиагүй тохиолдолд тендерт оролцох эрхгүй.

9.3. Тендерт ялагчаар шалгарсан оролцогчийн тавьсан дэнчинг хувьцааг худалдаж авах үндэс оруулан тооцно.

9.4. Тендерийн саналыг үнэлсний дараа тендерт оролцогч ялагчаар шалгаргаагүй тохиолдолд тендерийн дэнчинг тендерт оролцогчийн хүсэлтийн дагуу ажлын долоон /7/

өдөрт багтаан бүрэн буцаан олгох бөгөөд хүсэлтэд дэнчинг шилжүүлэх банкны дансны дугаарыг тодорхой заана.

9.5. Дэнчинг дараахь тохиолдолд буцааж олгохгүй:

- 1) Ялагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч хувьцаа худалдах, худалдан авах гэрээ байгуулах үндэслэл болох тендерийн үр дүнгийн тухай мэдэгдэл /тэмдэглэл/-д гарын үсэг зурахаас татгалзсан.
- 2) Ялагч нь хувьцаа худалдах, худалдан авах тухай гэрээний нөхцөл, болалын дагуу худалдан авах үнийн төлбөрийг хийгээгүй буюу хувьцаа худалдах, худалдан авах тухай гэрээнд заасан өөрийнхөө аливаа мэдэгдэл, баталгаа, тохиролцоогоо материаллаг байдлаар зөрчсөн.

9.6. Дэнчинд хүү төлөхгүй.

9.7. Дэнчин төлөхтэй холбогдсон банкны бүх зардлыг тендерт оролцогч хариуцна.

## Арав. Тендерийн санал бэлтгэн ирүүлэх

10.1. Компанийн нийт хувьцааны 80 хувийг худалдаж авах сонирхолтой стратегийн хөрөнгө оруулагчид Засгийн газраас дэвшүүлж буй дор дурдсан хувьчлалын зорилгыг хангах бизнесийн стратеги болон үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, тендерийн саналтай хамт ирүүлэх шаардлагатай. Үүнд:

- Компанийн үйл ажиллагааны үндсэн чиглэл болох боловсруулсан нефтийн бүтээгдэхүүний импорт, хангамжийн үйл ажиллагааг хэвээр үлдээж, цаашид өргөжүүлэх,
- Нефтийн бүтээгдэхүүний хангамжийн эх үүсвэрийг бизнесийн тогтсон туршлагатай уялдуулан өргөжүүлж, найдвартай болгох, бага өртөг бүхий хангамжийн сүлжээг үйл болгох, чанартай бүтээгдэхүүн, үйлчилгээний хангамжийг нэмэгдүүлэх,
- Аюулгүй ажиллагаа, байгаль орчны аюулгүй байдал, нефтийн бүтээгдэхүүний технологи, хадгаламжийн бааз болон шатахуун түгээх станцын стандартад тавих хяналтыг сайжруулах тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлэх,
- Компанийн барилга байгууламж, шатахуун түгээх станц, нефть хангамжийн баазуудыг шинэчлэх болон түүнийг олон улсын стандартад хургахад чиглэгдсэн хөрөнгө оруулалт хийх.

10.2. Тендерийн санал дараахь хоёр хэсгээс бүрдэнэ. Үүнд:

- Техникийн санал /бизнесийн стратеги болон үйл ажиллагааны төлөвлөгөөний хамт/,

## Санхүүгийн санал.

10.3. Техникийн болон санхүүгийн саналуудыг тус тусад нь битүүмжлэн дугтуйлж хүргүүлнэ. Саналуудын эх хувь болон хуулбаруудыг "ЭХ ХУВЬ", "ХУУЛБАР", "ТЕХНИКИЙН САНАЛ", "САНХҮҮГИЙН САНАЛ" гэж хаяглан тус тусад нь битүүмжлэн дугтуйлна. Эдгээр дугтуйг өөр дугтуйд давхар хийж битүүмжилнэ. Гаднах дугтуй дээр Төрийн өмчийн хорооны хаяг, тендэрт оролцогчийн албан ёсны нэр, хаягийг бичиж:

"НИК ХК-ийн хувьцааг худалдан авах нууц санал - Тендерийн Санал.

ШИНЖЭЭЧДИЙН БАГИЙГ

БАЙЛЦУУЛАХҮҮГИЙГЭЭР НЭЭХИЙГ ХОРИГЛОНО" гэсэн тэмдэглэл хийнэ.

Тендерийн саналыг Төрийн өмчийн хорооны дараахь хаягаар 2004 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн (Улаанбаатарын цагаар) 18.00 цагаас өмнө ирүүлнэ.

Л. Пүрэвдорж

Төрийн өмчийн хорооны дарга

Засгийн газрын IV байр, 410-р өрөө

Улаанбаатар-11, Монгол Улс

Утас: 976-11-312460

Факс: 976-11-312798

## 10.4 Техникийн санал

Техникийн санал нь худалдан авах үнийн дүнг ямар нэгэн байдлаар тусгахгүй байх бөгөөд дор дурдсан хэсгүүдээс бүрдэнэ. Үүнд:

### А.Тендэрт оролцогчийн талаархи мэдээлэл. Үүнд:

- (1) Тендэрт оролцогчийн бизнесийн үйл ажиллагааны чиглэл, компанийн бүтэц, нефтийн салбар болон нефтийн бүтээгдэхүүний бөөний болон/буюу жижиглэнгийн худалдаа зэргийг хамруулсан нефтийн салбар дахь түүний (консорциумаар оролцож байгаа тохиолдолд хамтарч буй компаниудын) үйл ажиллагааны дэлгэрэнгүй танилцуулга.
- (2) Сүүлийн гурван /3/ жилийн эцсийн байдлаар гаргаж аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан тэнцэл (хувьцаат компанийн хувьд хувьцаа эзэмшигчдэд зориулсан жилийн тайлан). Санхүүгийн тайлан тэнцлийг англи буюу монгол хэл дээр ирүүлнэ.
- (3) Тендэрт оролцогчийн нийт гаргасан буюу бусад хэлбэрээр өмчилж буй хувьцааны тав /5/-аас дээш хувийг эзэмшиж буй хувьцаа эзэмшигчдийн жагсаалт (консорциумаар оролцож байгаа тохиолдолд хамтарч буй компани тус бүрийн нийт гаргасан буюу бусад хэлбэрээр өмчилж буй хувьцааны 5 /тав/-аас дээш

хувийг эзэмшиж буй хувьцаа эзэмшигчид тус бүрийг энэхүү жагсаалтад оруулна), Тендэрт оролцогчоос тендэрт холбогдолтой гэж үзэн санал болгож буй бусад мэдээлэл.

### Б. Бизнесийн стратеги/Үйл ажиллагааны төлөвлөгөө

Хоёр /2/-оос доошгүй жилийг хамарсан энэхүү стратеги/төлөвлөгөөнд дор дурдсан арга хэмжээг тусгасан байвал зохино. Үүнд:

- (1) "НИК" ХК-ийн бизнесийн үндсэн чиглэлийг хэвээр хадгалж, цаашид хөгжүүлэх талаар санал болгож буй бизнесийн стратегийн тойм, Нефтийн бүтээгдэхүүний хангамжийн эх үүсвэрийг бизнесийн тогтсон туршлагатай уялдуулан өргөжүүлж, найдвартай болгох стратеги.
- (2) Компанийн одоо ашиглагдаж буй барилга байгууламж, шатахуун түгээх станц, нефть хангамжийн баазуудыг шинэчлэх, хугацаа, өртөг зардлын бүтэц зэргийг хамруулсан техникийн шинэчлэл хийх хөрөнгө оруулалтын төлөвлөгөө.
- (4) Хоёр /2/-оос доошгүй жилийг хамарсан борлуулалтын прогноз, үнийн бодлого, үйл ажиллагааны өртөг зардал, бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар зэргийг тусгасан маркетингийн төлөвлөгөө.
- (5) Хоёр /2/-оос доошгүй жилийг хамарсан санхүүгийн прогноз /орлого, үр дүнгийн тайлан, баланс, мөнгөн урсгалын тайлан, санхүүжилтийн эх үүсвэр/.
- (6) Ажиллагсдыг сургах сургалтын хөтөлбөр, удирдлага, зохион байгуулалтын хөгжил, гадаадын удирдлага/техникийн мэргэжилтнүүдийн бүрэлдэхүүн, тоо, албан тушаал зэргийг тусгасан хүний нөөцийг хөгжүүлэх төлөвлөгөө.
- (7) Нефтийн бүтээгдэхүүний технологи болон шатахуун түгээх станц, нефтийн агуулахын стандартад тавих хяналт, аюулгүй ажиллагаа, байгаль орчны аюулгүй байдлыг сайжруулах тусгай арга хэмжээг тусгасан байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө.

### С. Дэнчин төлснийг нотлох баримт

Г. Тендерийн энэхүү журмын сүүлчийн хуудсанд гарын үсэг зурсан хуулбар. Тендэрт оролцогч нь Тендерийн журамд гарын үсэг зурснаар энэхүү журмын



заалтыг сахин мөрдөх, түүнд тусгасан бүх нөхцөл, болзлыг хүлээн зөвшөөрснөө илэрхийлнэ.

**Д. Тендерт оролцохыг зөвшөөрч хуулийн этгээдийн удирдах байгууллагаас гаргасан шийдвэр** (консорциумаар оролцож байгаа тохиолдолд хамтарч буй хуулийн этгээд тус бүрийн удирдах байгууллагаас гарсан шийдвэр).

**Е. Тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч хувьцаа худалдах, худалдан авах гэрээний эцсийн төсөлд зохих ёсоор гарын үсэг зурж бусад бүх байдлаар бэлэн болгосон байх бөгөөд зөвхөн худалдан авах үнийг оруулах зайг хоосон үлдээнэ. Хоосон үлдээсэн зайг тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч зөвхөн ТӨХ-ны урилгаар бөглөж гүйцээнэ.**

Техникийн саналын эх хувьд хувьцаа худалдах, худалдан авах гэрээний эцсийн төслийн гарын үсэг зурсан бүх хувийг хавсаргана. Хувьцаа худалдах, худалдан авах гэрээний эцсийн төсөлд зориуд хоосон үлдээсэн хэсгийг тендерт оролцогчоор бөглүүлэхээс өөрөөр /худалдан авах үнийг оруулахаар хоосон үлдээсэн зайг оролцуулахгүйгээр/ ямар нэгэн өөрчлөлт оруулахыг үл зөвшөөрнө.

Хувьцаа худалдах, худалдан авах гэрээний эцсийн төсөлд дараах зүйлийг хавсаргана. Үүнд:

а) Хувьцаа худалдах, худалдан авах гэрээнд гарын үсэг зурахыг зөвшөөрсөн хуулийн этгээдийн удирдах байгууллагаас /буюу тендерт оролцогч консорциум болон оролцож байгаа тохиолдолд консорциумын гишүүн болох хуулийн этгээд тус бүрийн удирдах байгууллагын/ гаргасан шийдвэр

б) **Итгэмжлэгдсэн төлөөлөгчид дараахь эрх олгосныг нотлох итгэмжлэл:**

Гэрээнд гарын үсэг зурах, Санхүүгийн саналыг нээх ажиллагаанд Тендерт оролцогчийг төлөөлөх.

Тендерт оролцогчийн өргөдөл хавсаргасан итгэмжлэлд эдгээр эрхийг итгэмжлэгдсэн төлөөлөгчид олгосон тохиолдолд итгэмжлэлийн хувийг хавсаргана.

## 10.5. Санхүүгийн санал

Санхүүгийн санал нь "НИК" ХК-ийн 16760768 /арван зургаан сая долоон зуун жаран мянга долоон зуун жаран найман/ ширхэг хувьцааг худалдан авах үнээс бүрдэх бөгөөд энэ үнэ нь 6133000 /зургаан сая нэг зуун гучин гурван мянган/ ам. доллараас доошгүй байна.

## Арван нэг. Тендерийн саналын үнэлгээ

11.1. Төрийн өмчийн хороо тендерийн саналуудад үнэлгээ хийлгүүлэх зорилгоор шинжээчдийн багийг томилно. Тендерийн саналыг үнэлэх үйл ажиллагаа нь дараахь хоёр үе шаттай байна. Үүнд:

- Техникийн саналын үнэлгээ,
- Санхүүгийн саналын үнэлгээ.

11.2. Шинжээчдийн баг нь техникийн саналуудыг дор дурдсан шалгаруулах үзүүлэлтүүдийг үндэслэн онооны системээр үнэлнэ. Үүнд:

- 1) Тухайн салбарт үйл ажиллагаа явуулж ирсэн туршлага болон түүхэн замнал (0-40 оноо).
- 2) Санал болгож буй бизнесийн стратеги/үйл ажиллагааны төлөвлөгөөний чанар, Засгийн газраас дэвшүүлж буй хувьчлалын зорилгыг хүлээн авч тусгасан байдал (0-60 оноо).

Дэд үзүүлэлт:

Бизнесийн төлөвлөгөөний цар хүрээ, тодорхой байдал (0-10 оноо),  
Төлөвлөгөө, стратеги нь Засгийн газраас дэвшүүлж буй хувьчлалын зорилгод нийцсэн байдал (0-20 оноо),  
Компанийн одоо ашиглагдаж буй барилга байгууламж, шатахуун түгээх станц, нефть хангамжийн баазуудыг шинэчлэх, хугацаа, өртөг зардлын бүтэц зэргийг хамруулсан техникийн шинэчлэл хийх хөрөнгө оруулалтын төлөвлөгөө (0-10 оноо),  
Байгаль орчныг хамгаалах, аюулгүй байдлыг хангах төлөвлөгөө (0-10 оноо),  
Ажиллагсад сургалт явуулах хөтөлбөрийг тусгасан хүний нөөцийг хөгжүүлэхэд оруулах хөрөнгө оруулалтын хэмжээ, төрөл зэрэг хүний нөөцийг хөгжүүлэх төлөвлөгөө (0-10 оноо).

11.3. Техникийн үнэлгээгээр 70-аас доошгүй оноо авсан саналыг шалгаруулна.

11.4. Техникийн саналыг үнэлэх үйл ажиллагааг дуусгасны дараа шинжээчдийн баг нь техникийн саналын үнэлгээний тайлан гаргана.

11.5. Техникийн үнэлгээ дууссаны дараа Төрийн өмчийн хороо техникийн саналын үнэлгээгээр авбал зохих доод онооны болзлыг ханган тэнцсэн оролцогчдоод цаашид тендерт үргэлжлүүлэн оролцохоор шалгарсан тухай санхүүгийн саналыг нээхээр төвлөсөн газар, цагийг заан мэдэгдэнэ. Үүний зэрэгцээ Төрийн өмчийн хороо техникийн саналын үнэлгээгээр авбал зохих

доод онооны болзлыг хангаагүй оролцогчдод цаашид тендерт оролцохоор шалгараагүй болон дэнчин буцаан олгох тухай мэдэгдэнэ. Мэдэгдлийг буухиа шуудан, баталгаат захиа, факс буюу электрон шуудангаар явуулж болно.

11.6. Санхүүгийн саналуудыг тендерт оролцогчдын итгэмжлэгдсэн төлөөлөгчдийг байлцуулан нийтийн өмнө тендерийн хуваарьт заасны дагуу 2004 оны 2 дугаар сарын 17-ны өдөр задална.

11.7. Техникийн саналын үнэлгээгээр 70-аас доошгүй оноо авсан тендерт оролцогчдын санхүүгийн саналыг нээж үнэлнэ.

11.8. Тендерт оролцогчийн нэр болон "НИК" ХК-ийн нийт хувьцааны 80 хувийг худалдаж авахаар санал болгож буй худалдан авах үнийг чангаар уншиж, бүртгэнэ. Шинжээчдийн баг санхүүгийн саналын эх хувьд хувьцаа худалдах, худалдан авах тухай гэрээний эцсийн төслийг хавсаргаж, зохих ёсоор гарын үсэг зурсан эсэхийг шалгах ба санхүүгийн саналуудыг нийтийн өмнө задлах ажиллагааны тэмдэглэл хөтөлнө.

11.9. Санхүүгийн саналдаа хамгийн өндөр худалдан авах үнийн санал ирүүлсэн оролцогчийг тендерийн ялагчаар шалгаруулна.

11.10. Хоёр буюу түүнээс олон тендерт оролцогчид ижил үнийн санал ирүүлсэн тохиолдолд тэдгээрийг техникийн саналын үнэлгээгээр авсан онооны дагуу эрэмбэлнэ. Хэрэв техникийн саналын үнэлгээгээр авсан оноо нь мөн тэнцвэл худалдан авах үнийн шинэ саналыг нэг цагийн дотор бичгээр өгөх боломж олгоно. Шаардлагатай тохиолдолд энэ ажиллагааг аль нэг тендерт оролцогч нь илүү өндөр үнийн санал ирүүлэх хүртэл үргэлжлүүлэн явуулна.

11.11. Санхүүгийн саналыг албан ёсоор нээж үнэлсэн өдрөө шинжээчдийн баг нь тендерийн үр дүнгийн мэдэгдэл /тэмдэглэл/ийн төслийг бэлтгэж, Төрийн өмчийн хороогоор хянуулан батлуулах зорилгоор нээлттэй хуралдааны ажиллагааг түр завсарлана.

11.12. Шинжээчдийн баг, Төрийн өмчийн хорооны гишүүд мөн өдөр нээлттэй хамтарсан хуралдаан хийж, Төрийн өмчийн хорооны даргын гарын үсэг зурсан тендерийн үр дүнгийн мэдэгдэл /тэмдэглэл/-ийг уншиж тендерийн үр дүнг зарлана.

11.13. Ялагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийг тендерийн үр дүнгийн мэдэгдэл /тэмдэглэл/-д гарын үсэг зурж, хувьцаа худалдах, худалдан авах гэрээнд ялагчийн худалдан авах үнийг оруулахаар урих бөгөөд түүнд уг мэдэгдлийн гарын үсэг зурсан хувийг хуудас бүр дээр Төрийн өмчийн хорооны даргын гарын үсэг зурж үзэглэсэн хувьцаа худалдах, худалдан авах тухай гэрээний хувьтай хамт олгоно.

**Арван хоёр. Тендерийг явагдаагүй болон хүчингүйд тооцох, өргөдөл, санал ирүүлэх хугацааг сунгах**

12.1. Төрийн өмчийн хороо өргөдөл, санал ирүүлэх хугацааг өөрийн санаачилгаар, эсхүл тендерт оролцогчийн хүсэлтийн дагуу сунгах буюу тендерийн хуваарийг хэдийд ч ямар ч байдлаар өөрчилж болно.

12.2. Монгол Улсын Засгийн газар нь аль ч үед урьдчилан мэдэгдэлгүйгээр уралдаант шалгаруулалт /тендер/-ын журмын аль ч заалтыг хасах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах эрхтэй. Тендерийн журамд оруулсан аливаа өөрчлөлтийн талаар Төрийн өмчийн хороо бүх оролцогчдод бичгээр мэдэгдэнэ.

**Арван гурав. Гарын үсэг зурж байгуулсан худалдан, худалдан авах гэрээг цуцалсан тохиолдолд Төрийн өмчийн хорооноос авч хэрэгжүүлэх үйл ажиллагаа**

13.1. Энэхүү Тендерийн журмын дагуу байгуулж, гарын үсэг зурж, хүргүүлсэн Худалдах, худалдан авах гэрээг худалдах, худалдан авах ажиллагааг дуусгавар болгохгүйгээр аливаа шалтгаанаар цуцлах тохиолдолд Төрийн өмчийн хороо нь өөрийн үзэмжээр доорхи арга хэмжээний аль нэгийг авч болно:

- 1) Худалдан авах удаах үнийг санал болгосон Тендерт оролцогч этгээдэд (цаашид "Удаах байранд шалгарсан тендерт оролцогч" гэх) уг этгээдээс Тендерийн саналын хамт ирүүлсэн Худалдах, худалдан авах тухай гэрээний эцсийн хувилбарт гарын үсэг зурж, хэрэгжүүлэх саналыг бичгээр тавих;
- 2) Тендерийг дуусгавар болгох.

13.2. Энэхүү Тендерийн журмын 13.1 (1)-р зүйлийн дагуу Төрийн өмчийн хорооноос тавьсан саналыг удаах байранд шалгарсан тендерийн оролцогч нь хүлээн авахаас татгалзах буюу хүлээн авах тухайгаа Төрийн өмчийн хорооноос тогтоосон хугацаанд бичгээр мэдэгдэнэ. Тендерийн журмын 13.1 (1)-р зүйлийн дагуу Төрийн өмчийн хорооноос санал тавихаар шийдвэрлэсэн боловч тендерт ялагчийн санал болгосон үнийн удаах үнийг техникийн саналын үнэлгээгээр адил оноо авсан нэгээс дээш оролцогч санал болгосон тохиолдолд Төрийн өмчийн хороо удаах байрны тендерийн оролцогчийг Тендерийн журмын 11.10-р зүйлд заасан журмын дагуу сонгон шалгаруулна.

13.3. Энэхүү Тендерийн журмын 13.1 (1)-р зүйлийн дагуу Төрийн өмчийн хорооноос тавьсан саналыг Төрийн өмчийн хорооноос тогтоосон хугацаанд хүлээж авсан тохиолдолд удаах байранд шалгарсан Тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч нь дараахь бичиг баримтыг гаргаж өгнө:

- 1) Энэхүү журмын 13.1 (1)-р зүйлийн дагуу Төрийн өмчийн хорооноос тавьсан саналыг хүлээн авахыг зөвшөөрч тухайн хуулийн этгээдийн удирдах байгууллагаас (консорциум болон оролцож буй тохиолдолд тухайн консорциумын гишүүн этгээд тус бүрийн удирдах байгууллагаас) гаргасан хүчин төгөлдөр шийдвэр;
- 2) Итгэмжлэгдсэн төлөөлөгч удаах байранд шалгарсан тендерт оролцогчийг төлөөлөх, уг журмын 13.1 (1)-р зүйлд дурдсан үйл



ажиллагааг хэрэгжүүлэх эрхтэйг нотолсон хүчин төгөлдөр итгэмжлэл;

төндөрт оролцогчийн дараачийн этгээдэд Төндөрийн журмын 13.1(1)-р зүйлийн дагуу дахин санал тавих шийдвэрийн аль нэгийг Төрийн өмчийн хороо өөрийн үзэмжээр бие даан гаргаж болно:

- 3) Төндөрийн дэнчин төлснийг нотлох нотолгоо (удаах байранд шалгарсан Төндөрийн оролцогчийн төндөрийн дэнчинг буцааж өгөөгүй байсан бол дэнчинг төлсөн нотолгоог шаардахгүй).

- а) удаах байранд шалгарсан төндөрийн оролцогч нь энэхүү Төндөрийн журмын 13.1.(1)-р зүйлийн дагуу Төрийн өмчийн хорооноос тавьсан саналыг хүлээн авахаас татгалзсан, эсвэл Төрийн өмчийн хорооноос тогтоосон хугацаанд саналыг хүлээн авснаа мэдэгдээгүй,
- б) энэхүү Төндөрийн журмын 13.3-р зүйлийн дагуу шаардсан бичиг баримтыг гаргаж өгөөгүй,
- в) гэрээний талаар аливаа бусад шалтгаанаар Худалдах, худалдан авах гэрээг байгуулж, уг гэрээний нөхцөл болзлын дагуу худалдах, худалдан авах ажиллагааг дуусгавар болгож чадаагүй.

13.4. Удаах байранд шалгарсан Төндөрийн оролцогч нь энэхүү журмын 13.3-р зүйлд дурдсан шаардлагыг хангасан тохиолдолд уг оролцогчоос төндөрийн саналтайгаа хамт ирүүлсэн, худалдан авах удаах үнийг зааж бичсэн, Худалдах, худалдан авах тухай гэрээний эцсийн хувилбарт Төрийн өмчийн хорооны дарга гарын үсэг зурж, хуудас бүрийг нь үсэглэн итгэмжлэгдсэн төлөөлөгчид нь хүргүүлнэ. Талуудын харилцан тохиролцооноор Худалдах, худалдан авах тухай гэрээний төслийн эцсийн хувилбарт зайлшгүй өөрчлөлт (энэ нь нөхцөл байдал өөрчлөгдсөнийг зохицуулахад зайлшгүй шаардагдаж болох өөрчлөлтөөр л хязгаарлагдах ба удаах байранд шалгарсан Төндөрийн оролцогчийн санхүүгийн саналд тусгагдсан худалдан авах үнийн дүнг өөрчлөхгүй) оруулах бол энэхүү өөрчлөлтийг Худалдах, худалдан авах тухай гэрээнд оруулж, гэрээний хоёр тал тусгайлан үзэглэнэ.

Төндөрт оролцогчийн гарын үсэг

13.5 Дараахь тохиолдолд төндөрийг дуусгавар болгох букуу удаах байранд шалгарсан

Он, сар, өдөр

ХАВСРАЛТ 1

## ТӨНДӨРИЙН ХУВААРЬ

| Үйл ажиллагаа  | Огноо/Эцсийн мэдээ                         |
|--|--|
| Төндөрийн зар мэдээ  | 2003 оны 10 сарын 7                        |
| Өргөдлөө ирүүлэх   | 2003 оны 10 сарын 7 - 11 сарын 11          |
| Урьдчилсан шалгаруулалт/Төндөрийн баримт бичгийг хүргүүлэх                         | 2003 оны 10 сарын 21 - 11 сарын 25         |
| Компани дээр дүн шинжилгээ хийх/санал, дүгнэлт гаргах хугацаа                      | 2003 оны 10 сарын 21 - 2004 оны 1 сарын 30 |
| Хувьцаа худалдах, худалдан авах гэрээ /ХХХАГ/-ний төслийн талаар санал авах        | 2003 оны 12 сарын 9                        |
| ХХХАГ-ний шинэчилсэн төслийг боловсруулан гаргах                                   | 2003 оны 12 сарын 23                       |
| ХХХАГ-ний шинэчилсэн төслийн талаар санал авах                                     | 2004 оны 1 сарын 13                        |
| ХХХАГ-ний эцсийн төслийг бэлтгэн гаргах  | 2004 оны 1 сарын 27                        |
| Төндөрийн санал ирүүлэх  | 2004 оны 2 сарын 10                        |
| Техникийн саналыг үнэлэх   | 2004 оны 2 сарын 11 - 2 сарын 16           |
| Техникийн саналын үнэлгээний дүнг мэдэгдэх   | 2004 оны 2 сарын 16                        |
| Санхүүгийн саналыг олон нийтийн өмнө нээж үнэлэх/Төндөрийн үр дүнг нийтэд мэдэгдэх | 2004 оны 2 сарын 17                        |
| Гэрээнд гарын үсэг зурах   | 2004 оны 2 сарын 17                        |

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.  
Хаяг: <<Төрийн мэдээлэл>> эмхтгэлийн зөвлөл.

Улсын Их Хурлын Тамгын газрын  
Хэвлэх хэсэгт хэвлэв.

Улаанбаатар-12  
Төрийн ордон

☎ 329612  
Индекс 14003

☎ 329487  
Хэвлэлийн хуудас 2.5